

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2026 оны 06 дугаар сарын 03-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-7
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	8-46
1.Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төсөл /Засгийн газар 2026.05.25-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороодод хүргүүлнэ/	2-18
2..Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа нарын 19 гишүүн 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	18-35
3.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал, Ч.Анар, Ц.Мөнхбат, Л.Соронзонболд, Ж.Галбадрах нарын 5 гишүүнээс Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэх	35-42
4.Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн хүрээнд Монгол Улсад үр өгөөжтэй, ашиглах боломжтой, олон талт хэрэгцээ шаардлагад нийцсэн хиймэл дагуулын талаар судлан санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт	42-46

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 06 дугаар сарын 03-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Б.Заяабал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 15 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Н.Батсүмбэрэл, А.Ундраа, Д.Үүрийнтуяа, М.Энхцэцэг;

Чөлөөтэй: Р.Батболд;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар;

Тасалсан: Б.Жавхлан, О.Цогтгэрэл.

Нэг.Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төсөл /Засгийн газар 2026.05.25-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороодод хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэбаяр, мөн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Хүрэлбаатар, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, мөн яамны Соёл, урлагийн бодлого зохицуулалтын газрын дарга Д.Наранцэцэг, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн У.Марал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Э.Гансүх, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Анхтуяа, Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирал Ц.Батболд, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал Ж.Отгонбаатар, Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн захирал Э.Галбадрах, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал Т.Нарантуяа, Цэргийн төв эмнэлгийн дарга, ерөнхий эмч Б.Болор-Эрдэнэ, Дуурь бүжгийн эрдмийн театрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Алтанхуяг, мөн театрын Захиргааны хэлтсийн дарга М.Энхжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмацэрэн, зөвлөх Л.Батмөнх, Б.Нандингэрэл, референт Т.Билэг-Өрнөх, Б.Галсанбат, М.Мандхай нар байлцав.

Хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд З.Мэндсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, О.Батнайрамдал, С.Эрдэнэбат, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Сангийн сайд З.Мэндсайхан, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэбаяр, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирал Ц.Батболд, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал Ж.Отгонбаатар, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс санал хэлээгүй болно.

Б.Заяабал: Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	16
Татгалзсан:	6
Бүгд:	22

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороодын хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа нарын 19 гишүүн 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны дэд Ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны ерөнхий эдийн засагч Н.Батсайхан, Хуулийн газрын Гэрээ, эрх зүйн нийцлийн хэлтсийн захирал Ө.Мөнх-Ундарга, Хуулийн газрын Эрх зүйн бодлого, судалгааны хэлтсийн ахлах мэргэжилтэн М.Батсайхан, Санхүүгийн боловсрол, харилцааны газрын Санхүүгийн боловсролын хэлтсийн ахлах мэргэжилтэн М.Нургул, Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал, Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын дарга Б.Батчимэг, Компанийн засаглал, зохицуулалтын газрын ахлах зөвлөх А.Баянмөнх, Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Нандин-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, Б.Нандингэрэл, референт Т.Билэг-Өрнөх, Б.Галсанбат, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, М.Мандхай, Г.Уянгахишиг, Ч.Анар нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, Монголбанкны дэд Ерөнхийлөгч Г.Энхтайван, Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Б.Заяабал уг төсөлд Улсын Их Хурлын Тамгын газраар хууль зүйн дүгнэлт болон төсвийн нөлөөллийн дүн шинжилгээ гаргуулъя гэсэн горимын санал гаргав.

Б.Заяабал: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 16
Бүгд: 23
30.4 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Б.Заяабал: 1.Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

Б.Заяабал: 2.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Б.Заяабал: 3.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9

Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Б.Заяабал: 4.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Б.Заяабал: 5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Б.Заяабал: 6.Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал, Ч.Анар, Ц.Мөнхбат, Л.Соронзонболд, Ж.Галбадрах нарын 5 гишүүнээс Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мягмарнаран, мөн яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга Д.Батбаяр, Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, инновацын бодлого хариуцсан ахлах шинжээч М.Солонго, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Мэдээллийн технологи, систем нэгтгэлийн газрын дарга Б.Билэгдэмбэрэл, “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит аж ахуйн

тооцоотой үйлдвэрийн газрын Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийн хөгжлийг дэмжих хэлтсийн дарга Л.Ангараг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, Б.Нандингэрэл, референт Т.Билэг-Өрнөх, Б.Галсанбат, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Асуулгын хариуг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мягмарнаран танилцуулав.

Асуулгын хариутай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, С.Эрдэнэбат нарын тавьсан асуултад Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мягмарнаран, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Мэдээллийн технологи, систем нэгтгэлийн газрын дарга Б.Билэгдэмбэрэл нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Г.Очирбат, М.Энхцэцэг нар үг хэлэв.

Асуулга асуусан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал үг хэлэв.

Байнгын хорооны гишүүд Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал, Ч.Анар, Ц.Мөнхбат, Л.Соронзонболд, Ж.Галбадрах нарын 5 гишүүнээс Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэв.

Уг асуудлыг 16 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн хүрээнд Монгол Улсад үр өгөөжтэй, ашиглах боломжтой, олон талт хэрэгцээ шаардлагад нийцсэн хиймэл дагуулын талаар судлан, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, Б.Нандингэрэл, референт Т.Билэг-Өрнөх, Б.Галсанбат, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Г.Очирбат, М.Энхцэцэг нар үг хэлэв.

Байнгын хорооны дарга Б.Заяабал Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасныг үндэслэн Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны боловсруулсан тогтоолын төслийг уншиж танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Заяабал: “Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 6
Бүгд: 24
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны гишүүд Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн хүрээнд Монгол Улсад үр өгөөжтэй, ашиглах боломжтой, олон талт хэрэгцээ шаардлагад нийцсэн хиймэл дагуулын талаар судлан санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэв.

Уг асуудлыг 16 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 12 минут үргэлжилж, 32 гишүүнээс 24 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 27 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.ЗАЯАБАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхимд 12 цаг 15 минут

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Заяабал: Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая аа.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдээ танилцуулъя.

Хуралдаанд оролцохоор ирцэд орсон Чинбаатарын Анар гишүүн, Отгоншарын Батнайрамдал гишүүн, Пүрэвийн Батчимэг гишүүн, Шинэбаярын Бямбасүрэн гишүүн, Батжаргалын Заяабал, Жаргалсайханы Золжаргал, Чулуунбилигийн Лодойсамбуу, Ганзоригийн Лувсанжамц, Мэндбаярын Мандхай, Загджавын Мэндсайхан, Баатаржавын Мөнхсоёл, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Болдын Уянга, Гончигдоржийн Уянгахишиг, Саруулсайханы Цэнгүүн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Сүхбаатарын Эрдэнэбат гэсэн гишүүд ирцэд оржээ. Батбаярын Жаргалан гишүүн бас орж ирж байна.

Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралд гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 53.1 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2026 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.БНАУ-ын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн төслийг зөвшилцөх.

2.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүд.

3.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

4.Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

5.Улсын Их Хурлын гишүүн Золжаргал, Анар, Мөнхбат, Соронзонболд, Галбадрах нарын 5 гишүүнээс Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан асуулгын хариу.

6.Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооноос байгуулсан үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн хүрээнд Монгол Улсад үр өгөөжтэй ашиглах

боломжтой, олон талт хэрэгцээ шаардлагад нийцсэн хиймэл дагуулын талаар судлан санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт гэсэн 6 асуудал хэлэлцэхээр энэ 7 хоногийн тов дараалалд батлагдсан байгаа.

Үүнээс 2 дахь асуудал буюу Төрийн болон орон нутгийн өмчийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудаа эцэслэн бэлтгэж амжаагүй тул Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1-д заалтыг үндэслэн хуралдааны бэлтгэл хангагдаагүй гэж үзэн өнөөдрийн хэлэлцэх асуудлаас хойшлуулж байна аа.

Мөн 3 дахь асуудал болох Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэх хууль санаачлагчийн илтгэлийг танилцуулах ёстой Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Гонгорын Дамдинням сайд гадаад улсад албан томилолттой байгаа талаар мэдэгдсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.5 дахь хэсгийг үндэслэн өнөөдрийн хэлэлцэх асуудлаас мөн хойшлуулж байна аа.

Ингээд 4 асуудал үлдэж байна аа.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Өөр саналтай гишүүд байхгүй байна аа.

Ингээд эхний хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төсөл /Засгийн газар 2026.05.25-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороодод хүргүүлнэ/

БНАУ-ын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн төслийг зөвшилцөх хэлэлцүүлгийг явуулъя аа.

Хэлэлцээрийн төслийн талаарх төсөл санаачлагчийн танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд, Загджавын Мэндсайхан танилцуулна аа. Сайдын микрофоныг нээнэ үү.

3.Мэндсайхан: Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

БНАУ-ын Ерөнхийлөгч Александр Ван Дер Беллений 2025 оны 05 дугаар сард хийсэн Төрийн айлчлалын үеэр 60 сая Еврогийн эх үүсвэртэй санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийг байгуулах эрмэлзлийн захидлыг 2 улсын Сангийн яам хооронд байгуулсан. Хэлэлцээрийн хүрээнд Өрийн удирдлагын тухай хууль болон холбогдох журмын дагуу яамдуудаас санал авч Эдийн засаг, хөгжлийн яамнаас эдийн засаг, нийгмийн үр өгөөж, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт туссан байдлаар нь эрэмбэлсэн. Үүний дагуу төслийн жагсаалтыг Австрийн талд хүргүүлэн, Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн дүнг 65 сая евро

байхаар тохиролцсон бөгөөд тус эх үүсвэрээр ХСҮТ, ГССҮТ, Эх, хүүхдийн эрүүл мэндийн төв, Улсын 1 дүгээр төв эмнэлэг, Цэргийн төв эмнэлэг, Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэг, Улсын дуу бүжгийн эрдмийн театр зэрэг 7 байгууллагад нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг шинэчлэх, суурилуулах, хүний нөөцийг чадавхжуулах төсөл хэрэгжүүлэхээр төслүүдийн нэр дүнг хэлэлцээрийн хавсралтад тусгалаа.

Хэлэлцээрийн хүрээнд ашиглах зээлийн эх үүсвэр нь нэг хувийн хүүтэй, 0.9 хувийн хүүгийн баталгааны шимтгэлтэй, 19 жилийн хугацаатай, эхний 4 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй бөгөөд тус хэлэлцээр нь олон улсын гэрээний тухай хуулийн дагуу Монгол Улсын Их Хурлаар заавал соёрхон батлагдах гэрээ болно оо.

Иймд Монгол Улсын Засгийн газар болон БНАУ-ын Засгийн газар хоорондын санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрт гарын үсэг зурах эрх олгох тухай Ерөнхий сайдын захирамжийн төслийг хэлэлцэн дэмжиж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Заяабал: Баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя аа.

Мэндсайхан Сангийн сайд, Эрдэнэбаяр ЭМЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Гансүх БХЯ-ны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга, хурандаа, Отгонбаяр ХЗДХЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга, Хүрэлбаатар ЭМЯ-ны Санхүү эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Наранцэцэг Соёл, спорт аялал жуулчлал залуучуудын яамны Соёл урлагийн бодлого зохицуулалтын газрын дарга, Анхтуяа Улсын 1 дүгээр төв эмнэлгийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батболд ХСҮТ-ийн ерөнхий захирал, Галбадрах ГССҮТ-ийн захирал, Нарантуяа Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал хурандаа, Болор-Эрдэнэ Цэргийн төв эмнэлгийн эмнэлгийн дарга, ерөнхий эмч, хурандаа, Аз жаргал ДБЭТ-ын Захиргаа хэлтсийн дарга, Марал Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн гэсэн ийм ажлын хэсгүүд хүрэлцэн ирсэн байна.

Хэлэлцээрийн төслийн талаарх асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя аа. Гишүүд нэрсээ өгнө үү. Батнайрамдал гишүүнээр тасалъя. Ирцийн дагуу Лувсанжамц гишүүний микрофоныг нээе.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе. Хэлэлцээрийг дэмжиж байгаа агуулгын хувьд эрүүл мэндийн салбарт чиглэсэн эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авна гэсэн 65 сая еврогийн үнийн дүнтэй зээлийн хэлэлцээр, жилийн хүү 1.9 хувьтай юм байна. Энэ дээрээс Эдийн засаг, хөгжлийн яам өнөөдөр ирээгүй байх шиг байна тиймээ? Тийм учраас ЭМЯ-аас асууя.

5 жилийн үндсэн чиглэл, жилийн хөгжлийн төлөвлөгөө төсвийн 3 дугаар хавсралт буюу шалгуур үзүүлэлт байгаа. Энэ шалгуур үзүүлэлтүүд дээр энэ 65 сая еврогоор авч байгаа тоног төхөөрөмж маань ямар зүйл заалтыг сайжруулах вэ. Халдварт өвчний өвчлөл буурах юм уу, халдварт бус өвчлөлийн түвшин буурах юм уу? дундаж наслалт уртсахад нөлөө үзүүлэх үү гэдэг эхний асуулт.

Хоёрдугаарт Эдийн засаг, хөгжлийн яамнаас эрэмбэлэн ирүүлсэн төслийн жагсаалтын дагуу айлын талтай тохиролцсон төсөл арга хэмжээ гэсэн байна. Тэгэхээр энэ эрэмбэлэх аргачлалын талаар мэдмээр байгаа юм. Энийг ЭМЯ-наас заавар зөвлөгөөг Эдийн засаг, хөгжлийн яаманд өгч байна уу эсвэл Эдийн засгийн хөгжлийн яам өөрсдөө эрүүл мэндийн салбарт шаардлагатай төсөл арга хэмжээний үнэлгээний аргачлалыг боловсруулсан байна уу? Ийм 2 асуултад хариу авъя.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон уу? Эрдэнэбаяр дарга уу? 5 дугаар микрофоныг нээе.

Н.Эрдэнэбаяр: Та бүхний өдрийн амгаланг айлтгая аа. Лувсанжамц гишүүний асуултад хариулъя.

Тийм энэ ер нь бол энэ зээлийн хэлэлцээрээр авч байгаа тоног төхөөрөмжүүд маань яг энэ манай төрөлжсөн, мэргэжлийн, үндэсний хэмжээний ийм эмнэлгүүд дээр ер нь бид нар авч байгаа. Энэ бол яг одоо бид нарын энэ 5 жилийн үндсэн төлөвлөгөө, алсын хараа, мөн бас энэ 2027 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан энэ ажлуудын хүрээнүүд дээр явж байгаа. Өвчлөлийн байдлыг ер нь аваад үзвэл өнөөдөр өвчлөл нас баралт дээр бид нар халдварт бус өвчлөлүүд нэлээн өндөр байгаад байгаа.

Тэгэхээр энэ дээр ялангуяа бид нар энэ Монгол Улсад оношилж эмчлэхгүй байгаа 25 өвчний жагсаалт гэж батлагдсан байгаа. Мөн энэ хавдрын эмчилгээнүүд дээр зарим нэг нь орчин үеийн технологи шаардсан энэ эмчилгээний аргуудыг нэвтрүүлэх ийм зайлшгүй шаардлагууд байгаад байгаа. Тэгэхээр энэ чиглэл дээрээ яг одоо тухайлбал бид нар энэ халдварт бус өвчин энэ дотроо хавдрын эмчилгээ, хорт хавдрын навигаци, стеротактикийн оношилгоо эмчилгээний төв байгуулах гэсэн байдлаар тухайлбал яг ХСҮТ дээр бол энэ өмнө нь Монгол Улс яг хийж чадахгүй байгаа, эмчилж чадахгүй байгаа мэдрэлийн чиглэлийн хавдрууд дээр тухайлбал энэ төслийн үр ашиг зарцуулалтууд ингэж явж байгаа. Эх нярай дээр бид нар бол хүүхэд нярайн эндэгдлийг бууруулах чиглэл дээр ер нь энэ тоон үзүүлэлтүүдээс авч үзээд Тогтвортой хөгжлийн бодлогын 20, 30 хүртэлх энэ үзэл баримтлалын хүрээнд дээр Монгол Улсын хүрэх түвшнүүдийг тодорхойлж өгсөн байгаа. Энэ түвшнүүдэд хүрэхэд бид нарт зарим нэг үр дүнгүүд шаардлагатай байгаад байгаа. Ялангуяа энэ ургийн гаж хөгжлийн оношилгоо, ураг, нярайн мэс заслын тусламж үйлчилгээг сайжруулах тэгээд хүүхдийн эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслыг хөгжүүлэх гэдэг юм уу ингээд нэлээн олон зүйлүүдийг бид нар энд ажлын хэсгүүд дээр ярьж энэ яг бодлогын шинж чанартай өөрөөр хэлбэл энэ тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх гэдэг энэ зорилтуудын хүрээн дээр энэ төслүүд орсон байгаа. Тэгээд дараагийн нэг хэсэг нь бол энэ гэмтэл согог судлалын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, орчин нөхцөлийг сайжруулах гэдэг байдлаар тусгагдсан. Тэгээд энэ 4 жишээ нь эрүүл мэндийн яг салбар дээр байгаа 4 эмнэлгийн дотроос 3 эмнэлэг нь өмнө нь энэ төслүүдэд хамрагдсан эмнэлгүүд байж байгаа. Нэмэлтээр энэ жилээс Гэмтэл согог судлалын төв дээр энэ төсөл хэрэгжихээр байгаа. Энэ дандаа яг энэ зорилтууд дээр тусгагдаж тусламж

үйлчилгээний чанар хүртээмжээ дээшлүүлэх чиглэл дээрээ явсан энэ шалгуур үзүүлэлт рүүгээ илүү чиглэсэн ийм арга хэмжээнүүд байгаа.

Б.Заяабал: Лувсанжамц гишүүн нэмэлт тодруулга, микрофон олгоё.

Г.Лувсанжамц: Тийм. Байнгын хороо болон нэгдсэн чуулган дээр хэдүүлээ энэ шалгуур үзүүлэлтийн хэд дээр туссан зорилго зорилтод нийцэж байгаа төсөл арга хэмжээ юм бэ зээл юм бэ гэдгийгээ тодорхой хариулдаг байх хэрэгтэй байна аа. Жишээлбэл 3.4.1 дээр байгаа 5 жилийн үндсэн чиглэлийн хорт хавдраар оношлогдож эмчлэгдсэнээс хойш 5-аас дээш жил амьдарсан иргэдийн тоо ч юм уу. Ийм бодит зорилгууд бүгдээрээ тавьчихсан байгаа шүү дээ. Тэгэхээр яг яг энэ зүйл заалт дээр нэмэр болох төсөл арга хэмжээ юм гэдгийг тодорхой хариулдаг байвал их зүгээр байна тэ? Тийм тоонд байвал нэмж хариулж өгөхийг хүсэж байна. УДБЭТ дээр 10 сая еврогийн зүйл байгаа юм байна. Энэ ямар тоног төхөөрөмж явж байгаа. 5 жилийн үндсэн чиглэлийн ямар зорилго зорилтод нийцэж байгаа вэ гэдгийг тодруулж асууя.

Б.Заяабал: Эрдэнэбаяр дарга нэмэлт тодруулга өгье. 5 номерын микрофон.

Н.Эрдэнэбаяр: Лувсанжамц гишүүний асуултад нэмэлтээр хариулъя аа.

Энэ яг хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсанаар тухайлбал бид нар алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.2.13 дээр оношилгоо эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж иргэд эх орондоо бүрэн оношлогдон эмчлэгдэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ гадаадын иргэд манай оронд ирж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор эмнэлэг олон улсын магадлан итгэмжлэл авах үйл ажиллагааг төрөөс дэмжинэ гэсэн бас энэ үйл ажиллагааны хүрээ байж байгаа. Мөн энэ 2.2.15 дээр хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчний үеийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор олон улсын жишигт нийцсэн төвийг төрөлжүүлэн байгуулна гээд энэ дээр Зүрх судасны төв, Эрхтэн шилжүүлэн суулгах төв энэ бол манай улсын 1 дүгээр төв эмнэлэгтэй холбоотой энэ асуудлууд орж байгаа. Тэгээд мөн одоо Яаралтай тусламжийн үндэсний төв гэсэн байдлаар ингэж тусгачихсан байгаа. Мөн 2.2.28 дээр эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг төрөөс дэмжинэ гэдэг бас.

Б.Заяабал: Соёлын яамнаас байгаа юу? Соёлын яам 8 номер дээр нэмэлт хариулт өг.

Б.Бат-Эрдэнэ: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам ТНБД Бат-Эрдэнэ. Төсөл хэрэгжүүлэх үндэслэл бол Монгол Улсын алсын хараа-2050, мөн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Монголын нүүдлийн соёл иргэншил, орон нутгийн онцлогт тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээ, брэндийг хөгжүүлэх үйлчилгээний стандартыг олон улсын жишигт нийцүүлнэ. Энэхүү зээл маань 2015 онд яригдаж байсан. Австрийн талаас бол тус манай ер нь ДБЭТ дээр мэргэжлийн хүмүүс ирж үнэлэлт үнэлгээ өгч байсан. Мөн 2019 онд бас яригдаад ингээд энэ бол 3 дахь үе шат дээрээ яригдаж байгаа төсөл байгаа. Энэ одоогийн яг 10 сая долларын төсөл

бол зөвхөн тайзны тоног төхөөрөмж акустик шинэчлэл шинэчлэл хийх ийм төсөл байгаа.

Б.Заяабал: Батнайрамдал гишүүний микрофоныг нээе.

О.Батнайрамдал: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Мэдээж дэмжлэг яах вэ зээлийн хүү төлөгдөх зээлийн хүү 1.9 хувь гэж байна. Тэгэхээр бид нарт олдохгүй зээл байна л даа. Төлөх хугацаа нь 19 жилээр гэж. Миний бараг Улсын Их Хурал дээр сонссон хамгийн урт хугацааны зээл байх шиг байна 65 сая евро. Хамгийн гол нь нэгэнтээ буцаад энэ татвар төлөгчдийн мөнгөөр төлөгдөх учраас зөв газраа үр дүнтэй байгаасай л гэж бодож байгаа юм л даа. Тэгээд яах вэ хэрэгжүүлэгч байгууллагуудыг нь харах юм бол дандаа ер нь дийлэнх нь эрүүл мэндийн салбар руу явж байгаа юм байна. Зарчмын хувьд зөв гэж бодож байна. Тэгээд энэ асуулт болохоороо энэ жагсаалтаа нэг ёсондоо Засгийн газар эцэслээд оруулж ирж байна гэж ойлгож байгаа.

Тэгээд сая яах вэ Лувсанжамц гишүүн асуучихлаа л даа.

10 сая, 7 сая, 8 сая евро гээд. Тэгээд энэ дээр Засгийн газраас нэг зүйл асуучихмаар байна. 65 сая евро юм бол цаад талынхаа талдаа айлын талтай ерөнхийдөө салбар эд нарыг нь ямар зарчмын хувьд тохирсон байсан бол? Эсвэл 65 сая еврог бараг нэг эмнэлэг барьчихвал нэг том төсөл бүтэн дангаараа бүрдчих боломж байсан юм биш үү гэдэг зүгээр нэг ийм асуулт байна? Тэгэхээр энэний хуваарилалт ямар аргачлалаар хийгдээд орж ирж байгаа юм оо? Энэ асуултыг асууя.

Б.Заяабал: Сангийн яам 9 номерын микрофон нээж өгье.

С.Тулга: Сангийн яам Тулгаа гишүүний асуултад хариулъя. Энэ орчихсон байгаа эхний 6 эмнэлэг нь 6-аас 5 нь бол өмнө 2014, 2022, 2024 онууд дээр Австрийн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж байсан энэ төслүүд байгаа. Энэн дээрээ үргэлжлүүлээд явуулахад асуудал байхгүй гэж Австрийн тал мэдэгдсэн байгаа. Австрийн талаас бол зөвхөн тоног төхөөрөмж нийлүүлэх боломжтой байгаа. Хөнгөлөлттэй зээл өгч байгаа учраас. Нөгөө талдаа энэ нь болохоор яг өөрсдийнх нь энэ тоног төхөөрөмж нийлүүлж байгаа байгууллагуудаа дэмждэг ийм нөгөө 2 талын зээлийн онцлог нь тэр байдаг. Барилга байгууламж дээр санхүүжилт гаргах боломжгүй гэсэн ийм хариу Австрийн талаар хэлсэн. Тэгэхээр 1 том барилга бол энэ эх үүсвэрээ барих боломжгүй болчхоод байгаа. Тэгээд яах вэ эмнэлгийн тоног төхөөрөмж дээр нь нөгөө тоног төхөөрөмжийнхөө сургалт гэсэн ийм багцаар орж ирж байгаа. Дуурийн хувьд бол 2015, 2019 онуудын яриаг дагаад санхүүжилтийн хэмжээ нь тухайн зээлүүд дээр багтаагүй учраас энэ дээр үргэлжилж орж ирж байгаа ийм төслүүд байгаа.

Б.Заяабал: Батнайрамдал гишүүн нэмэлт тодруулга авах уу. Эрдэнэбат гишүүн асуулт асууна. Микрофоныг өгье.

С.Эрдэнэбат: Ямар ч байсан эмнэлгийн чухал тоног төхөөрөмжүүд ерөөсөө жоохон л ер нь дэмжиж байгаа. Гэхдээ бас асуудал байна аа. Австрийн тал чинь өөрийнхөө үйлдвэрлэж байгаа тоног төхөөрөмжүүдийг нийлүүлэх нь байна шүү дээ тийм үү? Тэгэхээр энэ зүгээр зээл юм чинь гэдэг байдлаар авах гээд байна уу? Яг энэ дотор чинь ямар тоног төхөөрөмжүүд байгаа юм бэ? Тухайлбал ингээд дандаа

лавлагаа шатлалын эмнэлгүүд байна. Тэгэхдээ манай гол чухал ялангуяа гадагшаа гарах урсгалыг хаахад энэ тоног төхөөрөмжүүд тэчнээн хүний гадагшаа явж үзүүлдэг ийм ийм зүйлүүдийг оронд нь нөхнө өө. Хүний нөөцийнх нь хувьд хэрхэн бэлтгэгдсэн юм бэ? Тэр нь зардал нь хэдэн төгрөг юм бэ? Ер нь барагцаалбал тоног төхөөрөмжийг нь дагаад. Тухайлбал статистикийн мэдээллээс харж байхад манай гадагшаа гарч байгаа валютын урсгалын багагүй хувь нь бараг жилдээ аялал зардалтайгаа нийлээд бараг 5 зуугаад сая доллар гэсэн байх аа? Энэ эрүүл мэндийн үйлчилгээ гадагшаа явж авах юманд зарцуулагдаад байгаа гэж байгаа юм.

Энэ тоног төхөөрөмжүүдийг авснаараа манайх хэчнээн валютыг Монголдоо авч үлдэх бололцоотой юм. Яг өнөөдөр хийхгүй байгаа ямар ямар үйлчилгээнүүдийг хийх бололцоотой юм гэдэг тал дээр мэдээлэл авмаар байна.

Хоёрдугаарт яах вэ иймэрхүү тоног төхөөрөмж зээл энэ асуудлыг нь ЭМД-ын Үндэсний зөвлөл зэрэг энэ байгууллагуудтайгаа ер нь ярьдаг уу? Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам л ингээд эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг яриад оруулж ирээд байгаа нь цаашдаа ер нь хэр зөв юм бол оо? Яах вэ манай эмнэлгүүд бол одоо чухал чухал эмнэлгүүд маань гэмтэл согог, хавдар судлал, Эх хүүхдийн эрүүл мэндийн төв гээд чухал эмнэлгүүд байна л даа. Яах вэ энэ дотор юу байж болохгүй юу? Одоо гишүүдээ хөдөө явахаар хөдөөгийн эмнэлгүүд чинь тоног төхөөрөмж гээд тун хэцүү байгаа шүү дээ. Тухайлбал нэг MRI-ийн аппарат, MRI-д үзүүлэх гэж мянган км-ээс хүмүүс зорьж ирж байна шүү дээ.

Тэгэхээр нөгөө төвлөрлийг улам бий болгох гэхээсээ илүүтэйгээр нөгөө бүсүүддээ ч гэдэг юм уу тэр эмнэлгүүдээ чадавхжуулах тал дээр энэ тоног төхөөрөмжүүд дагаж орж ирэх үү үгүй юу гэдэг талаар би тодруулж асуумаар байна. Тийм боломж байх уу, эс үгүй бол бүүр аль хэдийн тоног төхөөрөмжүүдийг нь яриад тохироод ийм хүрээндээ ингээд зөвхөн энэ 3 дугаар шатлалын эмнэлгүүд дээрээ тавих юм уу гэдгийг хэлмээр байна. Энэ дотор нөгөө нүдний хараа тэглэх гээд манай валютын хамгийн энгийн жишээ гэхэд Солонгос руу асар их урсгал бий болсон байна. Өвөр Монгол руу 27, 30 мянган хүн бараг тэнд очиж оношилгоо хийлгэх гэж явж байна гээд. Тэр хэрээрээ манай валютын урсгал гадагшлаад байгаа. Тэгэхээр та хэд нэг иймэрхүү хийсэн судалгаа байна уу? Энэ тоног төхөөрөмжүүдийг авснаараа тэчнээн хүний тийм үйлчилгээг сайжруулах бололцоотой. Бусад доод удам нь дүүрэг аймгийн бүсийн төвүүддээ ийм ийм дэмжлэг үзүүлэх боломжтой. Нөгөө энэ зайнаас нөгөө мэс засал хийх гэдэг тоног төхөөрөмж чинь орж байгаа юу? Хавдар судлал эд нараас асуухад.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 5 номер уу? 6 номерын микрофоныг нээе.

Ц.Батболд: Хавдар судлалын төв Батболд Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Мэдрэлийн нейрон навигац, нейрон статистик стеротактик эмчилгээний төвийг ХСҮТ-д байгуулах нэн чухал шаардлагатай байгаа. Учир шалтгаан юу вэ гэхээр мэдрэлийн гүний байрлалтай хавдрыг Монгол Улсад одоогоор мэс заслаар бол эмчлэхгүй байна. Тэгэхээр энэ гадаад урсгалыг 1 дүгээрт бууруулах, 2 дугаарт энэ мэдрэлийн мэс заслын гүний байрлалтай хавдрын эмчилгээний тохиолдлын 20 хувь нь гадагшаагаа явж эмчлүүлэх, 80 хувь нь Монгол Улсдаа эмчлүүлэх ийм тохиолдлууд байгаад байгаа.

Тэгэхээр нэг хүнд зарцуулж байгаа эмчилгээний зардлын тооцоо бол 500-аас 600 сая орчим төгрөгийн зардал гардаг. Энэ зардлыг гадагш нь урсгахгүй байх зорилготой, үндсэн зорилготой.

Дээрээс нь эмч нарын мэдлэг, ур чадвар, мэргэжлийн багаар ажиллах боломжийг олгох, гадаадад хийгдэж байгаа мэдрэлийн мэс заслын гүний байрлалтыг хийддэггүй байсан мэс заслуудыг Монгол Улсдаа нутагшуулах ийм том зорилготой хийгдэж байгаа төсөл юм байгаа юм аа.

Дээрээс нь хойд бүсийн хавдрын дэд төв дээр туяа эмчилгээний бункер болон туяа эмчилгээний вок стэйшн буюу хавдрын туяаны төлөвлөлтийг хийх ийм зорилготой. Учир шалтгаан юу вэ гэхээр хойд бүс буюу Хөвсгөл, Булган, Эрдэнэт, төвийн бүс дээр эндээ Сэлэнгэ болон Дархан аймгууд энэ 5 аймгийг ингээд харахад бол нэг хавдрын тусламж үйлчилгээний 17-19 хувийг үзүүлдэг. Тэгэхээр тусламжийн хүртээмжийг орон нутагт нэмэгдүүлэх ийм шаардлага байгаа учраас энэ төслийн гол ач холбогдол оршиж байна аа.

Б.Заяабал: 5 номерын микрофон нээе. Нэмэлт хариулт.

Н.Эрдэнэбаяр: Эрдэнэбат гишүүний асуултад нэмэлтээр хариулъя аа. Ер нь эрүүл мэндийн салбарт дээрх төслүүдээс нийт 74.5 сая еврогийн хэлэлцээрийн дүн бүхий 10 төсөл арга хэмжээ ер нь өмнө нь хэрэгжсэн байгаад байгаа юм. Тэгээд бид нар энэ дээрээ нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах технологийн 662 нэр төрлийн 3090 гаруй тоног төхөөрөмжийг 8 эмнэлэгт нийлүүлж эмнэлгүүдийн оношилгоо эмчилгээний чадавхыг сайжруулж тусламж үйлчилгээг олон улсын стандартад хүргэх орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлж иргэдийн оношилгоо эмчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлэх чиглэл дээр нэлээн их үр дүнгээ өгсөн гэж ингэж дүгнэсэн. Энэ төслүүдийн өмнө бүх эмнэлгүүд дээр энэ эдийн засгийн үр нөлөөний судалгаануудыг хийж үзсэн байж байгаа. Тухайлбал бид нар энэ эрхтэн шилжүүлэн суулгах Улсын 1 дүгээр төв эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах төслийн хүрээн дээр ингээд аваад үзэхээр аваад үзэхээр аваад үзэхээр гадаад улсууд руу жилд дүн шинжилгээ одоо 100 орчим эрхтэн шилжүүлэн суулгахаар зорьж байна.

Тэгэхээр энд нэг өртөг нь бол 350-аас.

Б.Заяабал: 5 номерын микрофоныг нэг минутаар сунгая.

Н.Эрдэнэбаяр: Дунджаар гаргасан тооцооллоор нэг хүн дээр 350-аас 450 сая төгрөг зарцуулж байгаа бөгөөд ойролцоогоор жилдээ 40-өөс 50 тэрбум төгрөг гадаад улс руу урсаж байна гэсэн ийм судалгаа гарсан байгаа. Тэгээд энэ төвөө бид нар ингэж байгуулж чадсанаар одоо ийм хэмжээний валютын хэмжээ урсгалыг дотооддоо үлдээж яг дотоодын даатгалынхаа сангаас гаргах боломжтой.

Дараа нь та бас орон нутгийн түвшнийг асууж байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр аймгуудын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах 225 сая долларын төсөл явж байгаа. Тэгэхээр нөгөө төвлөрлийг сааруулах хүрээн дээр бид нар бүх аймгуудыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чадавхжуулах, ялангуяа тухайн орон нутгийн түвшин дээрээ шаардлагатай байгаа энэ тусламж үйлчилгээгээ үзүүлэх боломжийг бүрдүүлнэ гэдэг байдлаар энэ

төслүүд хийгдээд энэ үе шаттайгаар ингээд энэ төслийн үйл ажиллагаанууд ингэж явж байгаа.

Б.Заяабал: Эрдэнэбат гишүүн нэмэлт тодруулга.

С.Эрдэнэбат: Яах вэ нөгөө төслийн үр ашиг гэдэг утгаар нь бид нар яах вэ Австралид олдож байгаа дээр нь гэдэг байдлаар авна гэхээсээ илүүтэйгээр өөр орнуудад гэдэг юм уу ийм өшөө шаардлагатай тоног төхөөрөмжүүд байгаа болов уу л гэж бодож байна. Магадгүй энэ дотроос гадна Германаас ч гэдэг юм уу Японоос ч гэдэг юм уу тэр утгаар нь би бол хэлж байгаа шүү. Түүнээс биш яах вэ бидний хувьд энэ чухал. Уул нь бол ЭМД болон бусад юугаараа жилдээ ядаж тэр сангийнхаа мөнгөний тодорхой нэг хувийн ч юм уу иймэрхүү дэвшилтэт технологи гадагшаа явах урсгалыг багасгах юм руугаа л бид нар тактикийн хувьд дотооддоо эмчилгээ үйлчилгээгээ сайжруулаад тэгээд хүний нөөцөө барьж чадвал өндөр тоног төхөөрөмжтэй, өндөр хүний нөөцтэй байх юм бол манайх эмнэлгийн эрүүл мэндийн аялал жуулчлалыг Монголдоо татах маш том боломж байгаа юм байна лээ гэдгийг хэлмээр байна. Тэгээд яах вэ тэр УДБЭТ-ын энэ төслийг дэмжиж байна гэж хэлье.

Б.Заяабал: Эрдэнэбат гишүүн санал хэллээ, үг хэллээ. Жаргалан гишүүний микрофоныг нээе.

Б.Жаргалан: Австри улсаас 65 сая еврогийн зээл авч нийтдээ 7 төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр оруулж ирж байгаа юм байна. Энэ 7 төслөөс яг тухайлсан 2 төсөл дээр тодорхой асуулт асууя. Нийт 8 сая еврогийн санхүүжилтээр Монгол Улсад эх хүүхэд нярайн эндэгдлийг бууруулах төсөл хэрэгжүүлэх гэж байгаа юм байна. Тэгээд энэ нярайн эндэгдэл гэдэг маш чухал үзүүлэлт байдаг. Тэгээд харамсалтай нь манай улсад сүүлийн жилүүдэд нярайн эндэгдлийн хувь хэмжээ буурахгүй яваад байгаа. Хамгийн сүүлийн үеийн тоо баримтыг харахаар мянган төрөл тутам 7.7 гэсэн нэг тоо яваад байдаг. Тэгээд яг энэ зээл авч хэрэгжүүлэх гэж байгаа төслийн хүрээнд нярайн эндэгдлийг яг ямар арга замаар ямар хувь хэмжээгээр ямар хугацаанд яаж бууруулах гэж байна?

Дээрээс нь одоо энэ нөгөө нярайн шарлалт их өндөр хувь хэмжээ эзлээд байгаа сүүлийн үед бол. Төрөлтийн бараг нэлээн олон хувь дээр шарлалттай хүүхдүүд бойжиж байгаа. Энэ чиглэлээр бас ЭМЯ холбогдох байгууллагуудаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ яг тодорхой ямар арга хэмжээнүүд байна гэдэг асуулт байна. Цаашид ер нь бол бид энэ хүүхэд нярайн н эрүүл мэндийн чиглэлээр дорвитой ажлуудыг зайлшгүй хийх шаардлагатай байгаа юм аа.

Хоёрдугаарт нь нийтдээ 10 сая еврогийн санхүүжилтээр ДБЭТ-ын тайз дуу авианы тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийнэ гэсэн байгаа. Тэгээд хэд хоногийн өмнө бас хэвлэл мэдээллийн хэрэгслээр Дуурь бүжгийн театрт их засвар орохтой холбогдуулаад тодорхой бус хугацаагаар Дуурь бүжгийн театр ажиллахгүй гэсэн нэг ийм мэдээ гарсан.

Тэгэхээр энэ засвар үйлчилгээтэй холбоотойгоор хэдий хугацаанд энэ дуурь бүжгийн театрын үйл ажиллагаа тасалдах юм бэ? Манай дуурь бүжгийн театр бол ер нь энэ сонгодог урлагийн маш том төв байдаг. Тэгээд ер нь бол ялангуяа энэ жуулчлалын улиралд бол ер нь ингэж тасалж байсан цаг хугацаа байдаг юм уу? Тэгээд яг ингээд үнэхээр тасалдах гээд байгаа юм уу? Тэгээд хэрэв их засварт ороод театрын үйл ажиллагаа тодорхой хугацаагаар зогслоо гэж үзэхэд театрын

жүжигчид уран бүтээлчид яах вэ? Яг энэ асуудал дээр ямар арга хэмжээ авч байгаа вэ?

Дээрээс нь энэ ДБЭТ-ын их засварыг хийгээд энэ архитектурт нь өөрчлөлт оруулна гэдэг болгоомжлол байдаг. Тэгэхээр ДБЭТ-ын барилга ч гэсэндээ Улаанбаатар хотын төв цэгт орших манай энэ уламжлалт, энэ баганат архитектурын, бас ийм томоохон ийм соёлын өв байж байгаа. Тэгэхээр энэ театрын барилгад өөрчлөлт оруулахгүй юм байгаа биз дээ. Ер нь цаашдаа энэ нөгөө театрын уламжлалт энэ архитектурынхаа хэв загварыг хадгалах нь маш чухал шүү гэдгийг хэлэх байна.

Тэгээд энэ ДБЭТ-ын энэ тайз, дуу авианы тоног төхөөрөмжийн шинэчлэл гэдэг нь яг их засварын ажиллагаа, барилгын бусад ажлууд явж байгаа юм уу? Өөр тодорхой төсөвт суучихсан тийм зүйл байгаа юу гэдэг 2 асуулт байна аа.

Б.Заяабал: Ажлын хэсэг гараа өргөөд байгаарай. 7 номерын микрофон нээе. Ажлын хэсэг өөрийгөө танилцуулаад.

Ж.Отгонбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Жаргалан гишүүний асуултад хариулъя. ЭХЭМҮТ Отгонбаатар байна аа.

2025 онд нярайн эндэгдлийн шалтгааны 30 хувь нь амьсгалын гачаал, 26.5 хувь нь тархины хүчилтөрөгчийн дутмагшил, 14.8 хувь нь төрөлхийн хөгжлийн гажиг, 5.2 хувь нь болох дээр төрөх үеийн бүтэлт эзэлж байгаа юм. Тэгэхээр бид нар бол энэ дээр багагүй хувийг төрөлхийн хөгжлийн гажиг эзэлж байгаа учраас төрсний дараа нярай үедээ тухайлбал эхний 28 хоногт нярайн эндэх тохиолдол их байгаа. Тэгэхээр бид нар энэ оношилгоог сайжруулахын тулд тоног төхөөрөмжийг энэ Австрийн төсөлдөө суулгаж өгсөн байгаа. Мөн манай эмнэлэг дээр бол үндэсний төв дээр 2025 онд эх ургийн анагаах ухааны баг гэж байдаг. Төрөлхийн хөгжлийн гажгийн 108 тохиолдлыг бид нар авч хэлэлцсэн байгаа. Эдгээрээс бол ер нь 77.9 хувь нь амьдарсан, 22.1 хувь нь эндсэн ийм байгаа. Тэгэхээр бид нар төрөлхийн хөгжлийн гажиг хамгийн эхний асуудал байна гэж бодож байгаа.

Хоёрдугаарт нийт төрөлтийн 8-аас 9 хувийг нь дутуу төрөлт эзэлж байгаа. Тэгэхээр бид нар дутуу төрөлтийг бууруулах чиглэл дээр ингэж ажиллаж байгаа гэсэн. Яг таны хэлдгээр яг нярайн шарлалт сүүлийн жилүүд ихэссэн байгаа. Энэ дээр тоног төхөөрөмж бол бид нар яг одоогийн байдлаар бид р сайжирсан байгаа. Энэ дээр Австрийн төсөл дээр нярайн шарлалтын юмнууд ороогүй байгаа. Төрөлжсөн мэргэжлийн нярайн тусламж үйлчилгээг сайжруулах мэс заслын тусламж үйлчилгээ сайжруулах аппарат тоног төхөөрөмжүүдийг Австрийн төсөлд суулгаж өгсөн байгаа.

Б.Заяабал: Жаргалан гишүүний бусад асуултуудад ажлын хэсгийн 8 номерын микрофон нээе.

Б.Бат-Эрдэнэ: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны ТНБД Бат-Эрдэнэ байна. 2 асуулт асуулаа. Энэ Австрийн Засгийн газрын зээлээр бол ер нь түрүүн бас гишүүд асууж байсан. Энэ зөвхөн техник тоног төхөөрөмжийн зээл байгаа. Энэ бол яг тайзны арын болон тайзан дээрх үндсэн засал мөн техник тоног төхөөрөмж, дуу авианы тоног төхөөрөмж үзэгчдийн сандал шинэчлэх ийм төсөл явж байгаа.

ДБЭТ-ын их засварын ажил бол улсын төсөвт энэ жил 8.2 тэрбум төгрөг суусан. Тендерийн сонгон шалгаруулалт зарлагдаад дотоодын ААН шалгарсан байгаа. Гаднах энэ архитектур болон бусад зүйлд архитектурт ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй. Энэ засвар бол зөвхөн дээвэр болон.

Б.Заяабал: Хариулт дээр 8 дугаар микрофон дахиж нээе. Нэг минут.

Б.Бат-Эрдэнэ: Дотор засал тоног төхөөрөмж дэд бүтцийн ажлууд явагдаж байгаа. Энэ нь өөрөө он дамнаж байгаа төсөл байгаа. Энэ жилийнх нь төсөвт өртөг нь бол 2.6 тэрбум төгрөг байгаа. Үйл ажиллагааг нь бол бүрэн зогсоохгүй бид нар төлөвлөөд бусад Драмын эрдмийн театр, Хүүхэд залуучуудын ордон гэдэг юм уу улсын энэ Улаанбаатар чуулга гээд бусад энэ театруудтайгаа ингээд төлөвлөөд үе шаттай ингээд бүрэн зогсоохгүйгээр төлөвлөж засвар хийж байгаа. Үгүй үгүй тийм юм байхгүй тийм.

Б.Заяабал: Баярлалаа. Гишүүд асуулт асууж дууслаа.

Хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү? Үг хэлэх гишүүд байхгүй байна. Гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулъя аа. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү.

Саналын томъёолол уншъя.

БНАУ-ын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

72.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

БНАУ-ын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн төслийг зөвшилцөх асуудлыг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ? Манай Байнгын хорооны гишүүдээс. Цэнгүүн гишүүн танилцуулна аа.

Хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа.

14.50 цаг

Хоёр.Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа нарын 19 гишүүн 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн талаарх хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Энхбатын Болормаа гишүүн танилцуулна. Гишүүний микрофоныг нээе.

Э.Болормаа: Эрхэм Байнгын хорооны даргаа, эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Хуралдаанд оролцож байгаа та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэж байгаа Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын санхүүгийн зах зээлийн цаашдын хөгжил, санхүүгийн үйлчилгээний хүртээмж, иргэдийн эрх ашгийг хамгаалах тогтолцоонд чухал ач холбогдолтой хуулийн төсөл юм аа. Сүүлийн жилүүдэд манай улсын санхүүгийн зах зээл өргөжин тэлж, банк, ББСБ, даатгал, үнэт цаас, төлбөрийн үйлчилгээ, финтек болон цахим санхүүгийн үйлчилгээний хэрэглээ эрчимтэй нэмэгдэж байна аа. Иргэд, өрх, жижиг дунд бизнес эрхлэгчдэд өдөр тутамдаа олон төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ авч, санхүүгийн гэрээ хэлцэлд оролцож байна аа. Гэвч санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл нэмэгдэж нөхцөл нь илүү нарийн төвөгтэй болохын хэрээр хэрэглэгчдийн мэдээлэл авах, ойлгох, харьцуулан сонгох, эрсдэлээ үнэлэх боломж бодит амьдрал дээр хангалттай биш байна.

Санхүүгийн байгууллага мэргэжлийн давуу байдалтай, харин хэрэглэгч мэдээллийн болон хэлэлцээрийн хувьд сул байр суурьтай оролцдог онцлог энэ салбарт түгээмэл байдаг аа. Үүний улмаас зээлийн бодит өртөг, хүү, шимтгэл, хураамж, гэрээний нэмэлт нөхцөл, хугацаа хэтрүүлсний хариуцлага, эргэн төлөлтийн дарамт, санхүүгийн бүтээгдэхүүний эрсдэлийн талаар хэрэглэгч бүрэн ойлголтгүй шийдвэр гаргах нөхцөл үүсдэг. Ийм нөхцөлд хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлыг зөвхөн тухайн иргэний хувийн асуудал гэж үзэж болохгүй ээ. Энэ нь санхүүгийн зах зээлд итгэх олон нийтийн итгэл, шударга өрсөлдөөн, өрхийн санхүүгийн тогтвортой байдал, цаашлаад эдийн засгийн тогтвортой өсөлттэй шууд холбоотой бодлогын асуудал аа.

Монгол Улс өнөөг хүртэл санхүүгийн салбарын зохицуулалтад голчлон байгууллагын төлбөрийн чадвар, зохистой харьцаа, эрсдэлийн удирдлага, санхүүгийн тогтвортой байдлыг хангах буюу макро зохистой зохицуулалтад төвлөрч ирсэн. Энэ чиглэл цаашид ч зайлшгүй чухал хэвээр байна. Гэхдээ санхүүгийн зах зээлийн хөгжил шинэ шатад шилжиж байгаа өнөө үед зөвхөн байгууллагын санхүүгийн зүүлтээр хязгаарлагдахгүй. Тухайн байгууллага хэрэглэгчтэй хэрхэн харилцаж байгаа, бүтээгдэхүүнээ хэрхэн санал болгож байгаа, мэдээллээ хэрхэн ил тод хүргэж байгаа, гэрээний нөхцөл нь шударга эсэх, гомдол маргааныг хэрхэн шийдвэрлэж байгаа зэрэг асуудлыг тусгайлан зохицуулах шаардлага бий болсон. Өөрөөр хэлбэл санхүүгийн салбарт зах зээлийн зан төлөвийн зохицуулалт хэрэглэгчийн эрхийг хамгаалах бие даасан тогтолцоотой эрх зүйн орчин бүрдүүлэх цаг болсон байна аа. Энэхүү хуулийн төсөл нь дээрх хэрэгцээ шаардлагад үндэслэн дараах 5 үндсэн агуулгыг тусгаж байна.

Нэгдүгээрт, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс хэрэглэгчтэй харилцахдаа баримтлах нийтлэг зарчим үүргийг тодорхой болгож байна. Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөл, үнэ, хүү, шимтгэл, хураамж, эрсдэл,

хэрэглэгчийн хүлээх үүрэг, хариуцлагыг хэрэглэгчдэд ойлгомжтой, бүрэн төөрөгдүүлэхгүй хэлбэрээр мэдээлэх нь энэ хуулийн үндсэн зарчмын нэг юм.

Хоёрдугаарт, хэрэглэгчийг мэдээлэлтэй шийдвэр гаргах боломжоор хангах зохицуулалтыг тусгаж байна. Санхүүгийн гэрээ байгуулахаас өмнө гэрээний гол нөхцөлийг танилцуулах, хэрэглэгчийн эрх, үүргийг ойлгомжтой тайлбарлах, хэт нэг талд давуу байдал олгосон, хэрэглэгчийн эрхийг үндэслэлгүй хязгаарласан шударга бус нөхцөлийг хязгаарлах асуудал энэ хүрээнд хамаарна.

Гуравдугаарт, санхүүгийн хэрэглэгчийн гомдол маргааныг шуурхай, хүртээмжтэй, зардал багатай, мэргэшсэн байдлаар шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэхээр тусгаж байна. Иргэн бүр бага дүнтэй эсхүл өдөр тутмын санхүүгийн маргаанаар шууд шүүхэд хандах нь цаг хугацаа зардал, мэдлэг, мэдээллийн хувьд хүндрэлтэй байдаг. Иймээс шүүхийн өмнөх шатанд хэрэглэгчийн гомдлыг үр дүнтэй шийдвэрлэх хараат бус, мэргэшсэн механизм бий болгох нь хуулийн төслийн практик ач холбогдлын нэг юм.

Дөрөвдүгээрт, Монголбанк болон СЗХ-ны санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиг үүрэг, хяналт шалгалт, зохицуулалтын бүрэн эрхийг тодорхой болгож байна. Ингэснээр зохицуулагч байгууллагууд зөвхөн хүүгийн байгууллагын төлбөрийн чадвар зохистой харьцааг хянах бус тухайн байгууллагын хэрэглэгчтэй харилцах үйл ажиллагааны ил тод, шударга, хариуцлагатай байдлыг хянах эрх зүйн үндэстэй болно.

Тавдугаарт, санхүүгийн боловсрол хэрэглэгчийн мэдлэгийг дээшлүүлэх асуудлыг бодлогын түвшинд тусгаж байна. Хэрэглэгчийг хамгаалах нь зөвхөн санхүүгийн байгууллагад хориг үүрэг тогтоох асуудал биш юм. Нөгөө талаас хэрэглэгч өөрөө санхүүгийн бүтээгдэхүүний нөхцөл өртөг, эрсдэл хариуцлагаа ойлгож, хариуцлагатай шийдвэр гаргах чадвартай байх шаардлагатай. Иймээс санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх нь энэ хуулийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм аа.

Эрхэм гишүүдээ,

Энэхүү хуулийн төслийн эдийн засгийн ач холбогдлыг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Юуны өмнө санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тогтолцоо бүрдсэнээр санхүүгийн байгууллагуудад итгэх иргэдийн итгэл нэмэгдэнэ. Итгэл бол санхүүгийн зах зээлийн үндсэн суурь юм. Хэрэглэгч гэрээний нөхцөлөө ойлгодог, маргаан гарвал шударгаар шийдвэрлүүлэх боломжтой, эрх нь хамгаалагдана гэдэгт итгэх нь санхүүгийн зах зээлийн хүртээмж, идэвхтэй оролцоог нэмэгдүүлнэ. Мөн шударга өрсөлдөөнийг ч дэмжинэ.

Хэрэглэгчид бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөлөө ил тод, ойлгомжтой танилцуулдаг. Хариуцлагатай үйл ажиллагаа явуулдаг байгууллага зах зээлд давуу байдалтай байх ёстой. Харин мэдээллийн давуу байдлаа ашиглан хэрэглэгчийг төөрөгдүүлэх, далд шимтгэл, хураамж ноогдуулах, гэрээний тэнцвэргүй нөхцөл тулгах явдлыг хуулийн түвшинд хязгаарлах шаардлагатай. Түүнчлэн өрхийн санхүүгийн дарамт хэт өрийн дарамтын эрсдэлийг бууруулахад эерэг нөлөө үзүүлнэ ээ. Хэрэглэгч зээлийн бодит өртөг, төлбөрийн хуваарь, хүү, шимтгэл, үүргийн гүйцэтгэл, хугацаа хэтрүүлсний үр дагаврыг ойлгож байж санхүүгийн зөв шийдвэр гарна. Энэ нь өрхийн санхүүгийн сахилга бат, төлөвлөлтөд чухал ач холбогдолтой.

Цаашлаад санхүүгийн зах зээлийн урт хугацааны тогтвортой байдалд хувь нэмэр оруулна. Хэрэглэгчийн эрхийг хамгаа тухайлах нь санхүүгийн байгууллагын эсрэг чиглэсэн бодлого биш, харин санхүүгийн байгууллага, хэрэглэгч 2-ын хоорондын харилцааг илүү тэнцвэртэй, ил тод, хариуцлагатай болгох замаар санхүүгийн салбарын тогтвортой хөгжлийг дэмжих бодлогын арга хэрэгсэл юм аа.

Эрхэм Байнгын хорооны гишүүд ээ,

Энэхүү хуулийн төсөл нь санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг хэт хязгаарлах зах зээлийн хөгжлийг сааруулах зорилготой биш ээ. Харин санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгчийн хоорондын харилцаанд шударга, ил тод, ойлгомжтой, хариуцлагатай стандарт тогтоох зорилготой. Олон улсын сайн туршлагаас харахад санхүүгийн зах зээл хөгжихийн хэрээр хэрэглэгчийн эрхийг хамгаалах бие даасан эрх зүйн орчин зайлшгүй шаардлагатай болдог. Манай улсын хувьд энэ асуудлыг цаашид салангид зохицуулах байгууллагын дотоод журам эсхүл ерөнхий иргэний эрх зүйн хүрээнд үлдээх нь хангалтгүй байна. Иймээс Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл нь иргэдийн эрх ашгийг хамгаалахаас гадна санхүүгийн зах зээлийн сахилга бат, хариуцлагатай үйлчилгээ, шударга өрсөлдөөн, хөрөнгө оруулагчдын итгэл эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих ач холбогдолтой гэж үзэж байна аа.

Хууль батлагдсанаар санхүүгийн үйлчилгээний нөхцөл илүү ил тод, ойлгомжтой болж, хэрэглэгчийн гомдол маргааныг шуурхай шийдвэрлэх боломж нэмэгдэнэ ээ. Мөн зохицуулагч байгууллагуудын хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиг үүрэг, хяналт, арга хэмжээний эрх зүйн үндэс тодорхой болж санхүүгийн байгууллагуудын хэрэглэгч төвтэй хариуцлагатай бизнес сийн соёл төлөвшихөд бодитой түлхэц үзүүлнэ ээ.

Иймд Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн хэлэлцэхийг дэмжиж өгөхийг эрхэм гишүүд та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Заяабал: Хууль санаачлагч Болормаа гишүүнд баярлалаа.

Болормаа гишүүнээс гадна энэ хуулийг өргөн барьсан, санаачилж өргөн барьсан гишүүдийг дуудаж танилцуулъя аа. Амарбаясгалан гишүүн, Ариунзаяа гишүүн, Баасанжаргал гишүүн, Батнайрамдал, Булгантуяа, Ганхүлэг, Жаргалан, Гантөмөр, Нарантуяа-Нара, Номин, Номинчимэг, Очирбат, Пүрэвдаваа, Сайнзориг, Саранчулуун, Соронзонболд, Энхнасан, Эрдэнэбат гэсэн гишүүд энэ хуулийн төслийг хамтран өргөн барьсан гэдгийг гишүүдэд танилцуулъя аа.

Ингээд ажлын хэсгийг танилцуулъя. Энхтайван Монголбанкны дэд Ерөнхийлөгч, Батсайхан Монголбанкны ерөнхий эдийн засагч, Мөнх-Ундарга Монголбанкны Хуулийн газрын Гэрээ эрх зүй, нийцлийн хэлтсийн дарга, Батсайхан Монголбанкны хуулийн газрын эрх зүйн бодлого судалгааны хэлтсийн ахлах мэргэжилтэн, Нургуль Санхүүгийн боловсрол харилцааны газрын Санхүүгийн боловсролын хэлтсийн ахлах мэргэжилтэн, СЗХ-оос Цэрэнбадрал СЗХ-ны дэд дарга, Дөлгөөн үнэт цаасны газрын дарга, Батчимэг Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын дарга, Авир компанийн засаглал комплайнсын хэлтсийн дарга, Баянмөнх Хяналт-шалгалт, зохицуулалтын газрын ахлах зөвлөх, Нандин-Эрдэнэ Хууль эрх

зүйн хэлтсийн мэргэжилтэн гэсэн ажлын хэсгийн гишүүд хүрэлцэн ирсэн байна аа. Мөн Байнгын хорооны хурал хурлын ирцийг дуудаж танилцуулснаас хойш Байнгын хороондоо хүрэлцэн ирсэн гишүүдийг уншиж танилцуулъя.

Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн, Ганбатын Очирбат гишүүн, Эрдэнэбилигийн Одбаяр гишүүн, Ренчинбямбын Сэддорж гишүүд маань хүрэлцэн ирсэн байгааг уншиж танилцуулъя аа.

Ингээд хуулийн хууль санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Эрдэнэбат гишүүнээр тасаллаа. Эрдэнэбат гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэбат: Энэ маш чухал хууль байгаа юм. Олон жил судлагдаад тэгээд удаа дараа хойшлоод суурь судалгаанууд аягүй сайн хийгдсэн. Тэгэхээр 1 дүгээрт бол гэрээний тэнцвэртэй байдлыг хангах маш чухал. Одоо ихэвчлэн бодит байдал дээр хүмүүс зээл авах, санхүүгийн үйлчилгээ авахад бэлэн бэлдсэн гэрээн дээр бараг цахимаар зөвшөөрч байна уу гэдэг ганц кноп дарахгүй бол цаашаа санхүүгийн хэрэглээг авч болохооргүй цахимжсан байгаад байдаг, эргээд ингээд аваад үзэхээр бол маш олон эрсдэлийг голцуу санхүүгийн үйлчилгээ авах хүмүүст л үүрүүлсэн байдлаар зохицуулаад байгаа нь яах вэ 1 дүгээрт бол санхүүгийн тэнцвэргүй байдал зах зээл дээр байгаа гэж байгаа.

Хоёрдугаарт, шүүхээр шийдэгдэж байгаа маргаан нь ялангуяа энэ аппликэйшний зээлтэй холбоотой аваад үзэхэд бол шүүхийн ихэнх маргааны дийлэнх нь энүүгээр шууд ингээд орж ирдэг. Үндсэндээ бол аппликэйшний зээл олгож байгаа байгууллагуудын талд шууд асуудал шийдэгддэг. Эргээд шүүхийн ачаалал асар ихээр нэмдэг ийм асуудал хүртэл байдаг юм байна лээ.

Гуравдугаарт ерөнхийдөө манай энэ банк санхүүгийн байгууллагуудын маржийн асуудал бас байгаад байдаг. Яах вэ хувийн банкнууд байгаа учраас бид нар ашгийг нь тэдэн хувь барих гээд хэлж байгаа зүйл ердөөсөө биш. Гэхдээ одоо дунджаар энэ ашгийнх нь марж ямар байна вэ?

Хоёрдугаарт хамгийн их нэг санал ирж байгаа нэг саналыг бол хэлэхгүй бол болохгүй байна. Ахмадын ингээд зээл гээд яахад манай ахмадуудад моргейжийн зээл гээд тавихаар үндсэндээ өгөхгүй гэдэг юм байна. Энэ бичигдээгүй хууль. Хууль дээр өгч болохгүй гэдэг юм байхгүй. Үндсэн хуулиар хүнийг нас, хүйс, ажил гарал үүслээр нь ялгарч болохгүй. Гэхдээ тэтгэвэрт гарчихсан ахмадуудыг орон сууцны зээл авахаас бичигдээгүй байдлаар шууд хасдаг.

Хоёрдугаарт юу вэ гэхээр ганц авч байгаа эх үүсвэр нь ахмадын тэтгэврийн зээл байгаа. Тэгээд батлан даагчийн нэг шаардлага тавьчихсан. Тэрийг нь ингээд харахаар таны төрсөн юм уу заавал ийм хамаатны хүн байна. Тэр нь бараг зээл ер нь бараг авч байгаагүй хугацаандаа заавал төлсөн байх ёстой энэ тэр гээд маш өндөр шаардлагуудыг шууд тулгаад ингээд шийдэж байгаа юм.

Тэгээд энэ цаагуураа юуг харуулж байна вэ гэхээр нэг талаар манай банк санхүүгийн байгууллагуудын цаана олигопол зах зээл байгаад байна аа. Хоорондоо үгсэн хуйвалдах байдлаар гэрээний нөхцөл юунууд нь бараг ижилхэн. Аль ч банк дээр очсон бараг ижилхэн шаардлага тавьдаг. Энэ юуг хэлж байна вэ гэхээр цаагуураа олигопол байгаа гэж илэрхийлж байгаа юм. Тийм учраас энэ гэрээний тавигдаж байгаа энэ шаардлагуудтай холбоотойгоор манай энэ холбогдох албаны

хүмүүсээс асуухад та бүгдэд энэ хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулаад тавихаар бодсон судалсан энэ гомдол маргаанууд хэр зэрэг ирдэг юм бэ? Энийг хэрхэн шийддэг юм бэ? Өөр энэ хуулиас гадна бусад Банкны тухай хууль болон бусад хуулиудад өөрчлөлт оруулах тийм хэрэгцээ шаардлага дээр хийсэн судалгаа тооцоолол байна уу?

Б.Заяабал: Ажлын хэсэг, хууль санаачлагчаас хариулт хэдэн номер вэ? Гараа өргөөрэй. 4 номерын микрофон нээе.

Г.Энхтайван: Монголбанкны дэд ерөнхийлөгч Энхтайван. Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Энэ хуулийн зохицуулалтын дагуу санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч буюу Монголбанк, СЗХ-оос тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн хэрэглэгчийн санхүүгийн чадамж хэрэгцээнд үндэслэн үйлчилгээ үзүүлэх, гэрээ байгуулахаас өмнө гэрээний нөхцөл, хүү, шимтгэл, хураамж, нэмэлт төлбөр, тэдгээрийг тооцох аргачлалыг тайлбарлаж, танилцуулж, гомдол хянан шийдвэрлэх, дотоод журам бүтэцтэй байх тухай мөн хэрэглэгчийн гомдлыг үнэ төлбөргүйгээр шийдвэрлэх, хэрэглэгчийн хувийн мэдээлэл, нууцлалыг аюулгүй байдлыг хангах тийм үүрэг хүлээж байгаа юм. Тэгэхээр гэрээний нөхцөлийн дагуу бол эдгээр гэрээний бүхий л нөхцөлүүдийг тухайн хэрэглэгчид дэлгэрэнгүй байдлаар танилцуулах нь энэ хуулиар олгогдож байгаа. Мөн гишүүн түрүүн хэллээ. Зохицуулагч үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь өөрөө давуу талтай болоод байдаг гэж байгаа юм. Яг энэ хуулийн дагуу жишээлбэл банк болон санхүүгийн байгууллагаас үйлчилгээ авч байгаа иргэн нь тухайн өөрийнх нь эрх зөрчигдсөн гэж үзээд энэ маргаан таслах байгууллагад өргөдөл гомдол гаргаад тухайн хэрэглэгчийн талд шийдвэр гарсан тохиолдолд тухайн үйлчилгээ үзүүлэгч мэргэжлийн байгууллага бол шүүхэд давж заалдах тийм эрхгүй байдлаар зөвхөн санхүүгийн хэрэглэгчийн эрх ашиг нь илүү хангагдах байдлаар энэ хуулийн төсөл дээр зохицуулалтыг оруулж өгсөн байгаад байгаа.

Гишүүн бас тодрууллаа. Банк санхүүгийн байгууллагуудаас гомдол хэр ирж байна гээд. Бид бүхэн банкны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах замаар банкны харилцагчийн эрх ашгийг хамгаалах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж өгөөд хадгаламж, харилцагчдын өргөдөл гомдлыг шийдвэрлэдэг. Ер нь бол нийт 2025 оны эхний байдлаар ирүүлсэн өргөдөл гомдлын 21.4 хувь нь зээлийн маргаантай холбоотой гомдол, 45 хувь нь зээлийн ангилалтай холбоотой гомдол байгаад байгаа. Тэгэхээр зээлийн ангилалтай холбоотой гомдол маань өөрөө энэ зээлийн мэдээллийн сангийн хуульд өөрчлөлт ороод тэгээд зээлийн оноо тооцдог болсноор энэхүү маргаан харьцангуй бас цэгцэрнэ гэж төв банк үзэж байгаа. Ер нь бол банк санхүүгийн байгууллага тэр дундаа банкны салбарын гомдол бол дийлэнх нь энэ тухайн харилцагч өөрөө гэрээний нөхцөлөө бүрэн гүйцэд танилцаагүй тухайн банкнаас өөрийнх нь танилцуулсан гэрээн дээр бол танилцалгүй гарын үсэг зурсантай холбогдсон бол энэ маргаан үүсдэг. Энэ хуулиар бол энийг заавал зохицуулагч байгууллага нь тухайн иргэнд танилцуулж, тухайн иргэний зөвшөөрлийг авах зохицуулалттай болж ирж байгаа. Тэгээд мөн даатгал, үнэт цаас, ББСБ, ХЗХ мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч мөн вертуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой гомдлыг энэ хуулиар зохицуулах тийм Омбудсмен бол энэ чиглэлийн байгууллагуудын гомдлыг зохицуулах үүрэг хүлээж байгаа. Яг эдгээр СЗХ-ны зохицуулалттай салбаруудад хэдий хэмжээний гомдол ирсэн талаар статистикийг СЗХ хэлэх байх.

Б.Заяабал: Ажлын хэсгийн нэмэлт тайлбар 3 номер.

Т.Цэрэнбадрал: 2025 оны байдлаар СЗХ-н дээр нийтдээ 976 өргөдөл гомдол ирсэн байгаа. Үүнээс даатгалын чиглэлээр 475 буюу 49 хувь нь, үнэт цаасны чиглэлээр 128 буюу 15 хувь, ББСБ-ын чиглэлээр 207 буюу 23 хувь гэхчлэн ирсэн байгаа. Эндээс харахад бид банк санхүүгийн байгууллагуудын зээлийн үйлчилгээ болон даатгалын гэрээтэй холбоотой нөхцөлүүдийг хэрэглэгчид бүрэн дүүрэн мэдээлэлтэй байх. Ялангуяа даатгалын энэ 49 хувь ирж байгаа дээр зайлшгүй даатгалын гэрээнд хамрагдахгүй нөхцөлүүдийг даатгуулагч өөрөө хүлээн зөвшөөрч, ойлгож, баталгаа гаргаж гарын үсэг зурж байхаар ийм зохицуулалтууд орж байгаа.

Тэгэхээр энэ үүднээсээ харах юм бол санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тал дээр нэлээд ахиц гарна гэж бид харж байна.

Б.Заяабал: Нэмэлтээр нэг минут хууль санаачлагч Болормаа гишүүний микрофоныг нээе.

Э.Болормаа: СЗХ-ны энэ албан ёсны мэдээлэл болохоор яг гомдол нэг 900 гаруй гэж гарч ирж байгаа юм л даа. Тэгээд энэ жилээс жилд нэг ойролцоогоор иймэрхүү. Гэхдээ асуудлын ер нь цар хүрээг харахад бид нар банкны дотоод аудитын тайланг 11 банкны дотоод аудитын тайланг нэгтгээд харахад зүгээр жишээлэхэд нийтдээ 47 мянган зөрчил илэрсэн байгаа. Тэрний 99 хувь нь иргэдийн, үлдсэн хэсэг нь буюу нэг хувь нь бол ААН-тэй холбоотой. Үүнээс яг энэ хугацаанд банканд иргэдээс гомдол гаргасан тоог харахаар 6.5 мянга байгаа юм. Тэгэхээр 47 мянган зөрчил илэрсэн боловч 6.5 мянган яг гомдол албан ёсоор банканд гаргана гэдэг жишээ нь нийт зөрчлийн нэг 14 хувь нь л гомдол болж байгаа юм. Тэгэхээр маш олон хүмүүс албан ёсоор банкандаа байна уу, банк бусдаа байна уу? СЗХ байна уу? Монголбанканд гомдол мэдүүлэхгүй байгаа маш олон хүмүүс хэдэн мянгаараа цаана нь байгаа гэдгийг онцолж хэлье.

Б.Заяабал: Эрдэнэбат гишүүний микрофоныг нээе. Нэмэлт тодруулга.

С.Эрдэнэбат: Нөгөө энэ хуулийг яах явцад нэлээдгүй хүмүүс энийг ирүүлдэг нь банк санхүүгийн байгууллагууд өөрсдөө зээл өгөх нэрийдлээр санхүүгийн хэрэглэгчийн санаа гэдэг юм уу бизнесийн ноу хау гэдэг юм уу ашиглах ийм асуудал хэр зэрэг тийм гомдол санал ирдэг вэ гэдгийг тодруулж асуумаар байна, нэг.

Хоёрдугаарт моргейжийн зээл гэдэг юм уу ийм зүйлийг харж байхад өөрийнх нь банкнаас гэдэг юм уу өөрөөс нь зээл авсан байгууллагуудаас тэр орон сууц авахыг тулган шаарддаг, санал болгодог, давуу эрхээ санал болгодог гэдэг ийм асуудлууд гараад байдаг юм. Энэ тал дээр та хэдийн хувьд хийсэн судалгаа байна уу? Моргейжийн зээл дээр Монголбанканд дээр шалгалт оруулсан гэсэн. Тэрний дүн гарсан уу гэдэг ийм асуулт байна.

Б.Заяабал: Хууль санаачлагч Болормаа гишүүн эхлээд хариулъя.

Э.Болормаа: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя аа.

Эрдэнэбат гишүүн түрүүн ахмадуудын моргейжтэй холбоотой асуудал ярьсан болохоор тэрэн дээр нэг онцолж хариулъя гэж бодож байна. Яг энэ хуулийн төсөлд энэ асуудал тухайлан тусгагдаагүй боловч ахмадуудын тэтгэврийн зээлтэй холбоотой асуудал дээр Эрдэнэбат гишүүн та маш их манлайлж бас эндээс бид нар

үүдэлтэйгээр бас энд оруулсан заалтаа хэлье гэж бодож байна. Ахмадуудын тэтгэврийн зээлтэй холбоотойгоор тэтгэврийн хүүг урьдчилан авч байна гэдэг ийм гомдол нэлээд их ахмадууд танд мэдүүлж та үүнийг уламжилж хэлж байсан? Тэгэхээр яг үүнийг хориглох заалт энд онцгойлон орсон байгаа гэдгийг хэлье. Тэгээд яг сая моргейжтой холбоотой асуултад ажлын хэсгээс нэмж хариулъя аа.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Г.Энхтайван: Өнгөрсөн оны 12 дугаар сард ипотекийн зээлийн олголт хэрэгжилттэй холбоотой шалгалтыг арилжааны банкнуудад хийсэн байгаад байгаа. Тухайн арилжааны банканд хийсэн шалгалтаар бол нийтдээ 140 гаруй мянган ипотекийн зээлийн олголт энэ дээр давхардаж олгогдсон журмын бус олгогдсон эсэх дээр хяналт шалгалтыг Төв банкнаас хийсэн. Энэ хяналт шалгалтын хүрээнд 1600 орчим иргэн 2 удаа мөн, 4 хүн 4 удаа, 80 орчим хүн 3 удаа авсан тийм зөрчил илэрсэн байгаад байгаа. Тэгэхдээ 2016 оноос хойш бол энэ буюу ипотекийн зээлийн энэ журам шинэчлэгдсэнээс хойш энэхүү зээлийг тэгж давхардуулан авсан тохиолдол илрээгүй. Арилжааны банкнууд бол тухайн Монголбанкнаас баталсан ипотекийн зээлийн журмын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа юм. Ипотекийн зээлийг бол хоёрдогч.

Б.Заяабал: Нэмэлт авах уу? Нэмэлт нэг минут өгчихье 4 номер дээр.

Г.Энхтайван: Ипотекийн зээлийг хоёрдогч зах зээл дээр Монголын ипотекийн корпорац худалдаж авдаг учраас энэ зээлийн давхардлыг бол ипотекийн корпорац давхар шалгадаг. Тэгээд төв банкнаас гаргасан журмын дагуу давхардсан зээл байхгүй байгаад байгаа. Ер нь бол энэ мянга хэдэн зуун хүн авсан тохиолдлууд тэр бол 2016 оноос өмнө авсан. Зарим нэг тохиолдолд давхардсан гэгдэж байгаа хүмүүс нь болохоор 8 хувийн зээл болон 6 хувийн зээлийг аль алийг нь авсан байгаад байгаа. Энэ нь болохоор 8 хувийнхаа зээлийг хааж дуусгаад 6 хувь руу шинээр авсан гэсэн үг. Тэгэхээр аль алин дээр нь ийм бүртгэл ороод байгаа ийм асуудал байгаа.

Б.Заяабал: Нэмэлт тодруулга Эрдэнэбат гишүүн микрофоныг нээе.

Тэгэхээр яах вэ ипотекийн зээл ч бай тэр нөгөө хяналт шалгалтын нөгөө гарсан гол үр дүнгүүдтэй холбоотойгоор хэчнээн магадгүй шууд харж болно шүү дээ. Тийм тийм төслүүдийг энэ банк санхүүжүүлээд тэндээс нь жишээлбэл ипотекийн зээл ихэвчлэн тэдэн хувийг нь авсан байна гэдэг тоо харахад бол энэ дээр тодорхой дүгнэлт хийж болно.

Хоёрдугаарт, тэр тухайлбал ахмадын зээл ч гэдэг юм уу гэнэт ингээд шууд олгоно, олгохгүй, эс үгүй бол шууд ийм нөхцөл тавина гээд ингээд бүх банкнууд ингээд хоорондоо ярьчихсан юм шиг ийм асуудал тавиад байгаа чинь асуудал байгаад байна тийм үү? Тэгэхээр Монголбанкны тэр мөнгөний бодлого гэдэг юм уу тодорхой хяналт шалгалт гэдэг юм уу орон тооны бус зөвлөлд нь санхүүгийн хэрэглэгчийн төлөөлөл гэдэг ийм төлөөллийг бий болгох цаг нь болсон юм биш үү? Зээлдэгчдийн төлөөлөл гэсэн үг. Тэгээд энэ тал дээр та бүгдэд ямар санал юу байгаа вэ?

Б.Заяабал: 4 номерын микрофон.

Г.Энхтайван: Түрүүн гишүүн асуусан. Энэ дээр хариулахаа мартчихаж. Энэ банк санхүүгийн байгууллагууд иргэн төсөл бичээд өгөхөөр тухайн төслийг нь аваад банкны зээлийн эдийн засагч ч юм уу банкны удирдлагууд хувьдаа ашиглаад ийм асуудал гаргаад байгаа тохиолдол. Энэ дээр бол төв банканд дээр яг энэнтэй холбоотой гомдол ирж байгаагүй. Бид бүхэн бол яг энэнтэй холбоотой яг ийм нөхцөл байдал гарах юм бол энэ тухайн хүний оюуны өмч болон бусад өөрийн хийсэн төслийн нууцтай холбоотой асуудал учраас энэ дээр бол хэрвээ яг ийм асуудал гарсан бол төв банканд гомдол гаргаад явах эрх нь нээлттэй байгаа. Энэ дээр төв банк тухайн арилжааны банканд хяналт шалгалтын журмаар албадлагын арга хэмжээ авах бүрэн эрхтэй байгаад байгаа. Түрүүн энэ арилжааны банкнууд өөрсдийн төслүүдийг тухайлан ипотекийн зээлээр санхүүжүүлээд байгаа гэсэн тийм хардлага байдаг. Энэ дээр яг ипотекийн зээлийг олгосон байршлаар нь аваад үзэх юм бол өнгөрсөн 2013 он оноос хойш хэрэгжсэн ипотекийн зээлийн бараг үндсэндээ.

Б.Заяабал: Мандухай гишүүний микрофоныг нээе ээ.

М.Мандхай: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Одоо өнөөдөр бол иргэн, банк, ББСБ энэ финтек, даатгал зэрэг гээд ингээд дандаа мэргэжлийн байгууллагуудтай гэрээ хийж байгаа. Гэхдээ яг энэ хэрэглэгчтэй холбоотойгоор тэр 2 талын тэр мэдлэг мэдээлэл энэ хэлэлцэж байгаа асуудал шийдвэрлэж байгаа гомдлыг шийдвэрлэж байгаа бодит байдал бол өөрөө тэнцүү бус явж ирсэн. Тэгэхээр би энэ одоо өөрөө даатгалын ажлын хэсгийг ахалж байгаа хүний хувьд бас яг энэ асуудал бас л яг адилхан тулгамдаад байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр энэ зохицуулагчдын хоорондын уялдаа холбооны асуудал байгаад байгаа юм. Нэгэнтээ тусдаа хуулиар зохицуулах нь өөрөө зөв. Гэхдээ энэ өөрөө хууль хэрэгжих ёстой бодитой яг хэрэгжих шаардлага хэрэгцээ байгаад байгаа юм. Тэгэхээр энэ одоо бол Монголбанк, СЗХ өрсөлдөгч нөгөө хэрэглэгчийг хамгаалах газар байгаа шүү дээ. Тэгээд энэ 3 газрын яг энэ үнэхээр хэрэглэгч өөрөө гомдол гаргаад гомдлоо шийдвэрлүүлэх гээд явахад гол энэ Монголбанк, СЗХ өөрөө илүү зохицуулах нөгөө байгууллагуудаа хянах ийм чиг үүрэг нь давамгайлчихсан. Яг хэрэглэгч буюу одоо жишээлбэл даатгал дээр даатгуулагчийн эрхийг хамгаалаад байгаа зохицуулалт нь харьцангуй бага байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр энэ байгууллагууд хоорондын энэ үүрэг зааг чиг үүргийг тодорхой энэ хууль дээр зааж өгсөн үү энэ нь тодорхой байгаа юу гэдгийг нэг асуучихъя аа.

Хоёрт нь финтек цахим үйлчилгээ гэдэг хамгийн том толгойны өвчин. Энэ хуулийн төсөлд энэ цахим мөнгө, цахим хуулга, энэ цахим зээл гээд энэнтэй холбоотой шинэ бүтээгдэхүүнд хэрэглэгчийн эрхийг хамгаалах ямар ер нь зохицуулалтуудыг тусгаж оруулж өгсөн бэ гэдэг асуултыг асууя.

Дараа нь энэ үнэлгээтэй холбоотойгоор энэ хууль дээр малчин өрх тариаланч энэ хоршоо, бичил бизнесийн санхүүгийн хэрэглэгчид хамрагдах уу? Энэ эсвэл зөвхөн хувь иргэн гэдэг арай өөр зохицуулалтаар явж байна уу гэдгийг тодруулъя. Тэгээд дахиад үүнтэй холбоотойгоор ХАА-н энэ улирлын орлоготой зээлдэгчийн төлбөрийн энэ чадварыг банк энэ ББСБ хэрхэн үнэлэх вэ? Тухайлбал одоо энэ нөгөө зуд, ган энэ ургацын алдагдал гээд энэ эрсдэлүүд байдаг. Тэгэхээр эдгээр энэ эрсдэлүүдийг тусгайлан ер нь харгалзаж үзэх үү? Ингээд асуултаа асуучхаад тэгээд тодруулъя.

Б.Заяабал: Хэн хариулах вэ? Хууль санаачлагч Болормаа гишүүнээс эхлээд хариулъя.

Э.Болормаа: Мандхай гишүүний асуултад хариулъя.

Энэ хуулийн төслийн гол зорилгын одоо тулгамдаж байгаа асуудлыг та маш сайн онцолж хэллээ. Ер нь мэргэжлийн байгууллагатай гэрээ хэлэлцээрт орж байгаа тул хүчний хувьд гэх юм уу даа тэнцвэргүй ийм гэрээний эрх зүйн харилцаанд орж байгаа энэ зохицуулагч байгууллагуудын хоорондын хоорондын уялдаа юу байх вэ гэхээр энэ хуулийн үр дүнд маргаан шийдвэрлэх байгууллага гэж бий болж байгаа. Түүнд омбудсмен буюу иргэн гомдлоо гаргахад тэр гомдол дээр нь 30 хоногийн дотор шийдвэр гаргадаг бүүр яг шийдвэр гаргах үүрэгтэй ийм байгууллага бий болж байгаа. Сая намар жишээлбэл дахин тэтгэврийн зээлтэй холбоотой асуудлыг ярихад бид нар ахмадууд жагсаад, Монголбанкны үүдэнд очиж жагсаад алив Лхагвасүрэн Ерөнхийлөгчийн хаана байна гээд тэр үүдээр нь ч оруулахгүй байгаа шүү дээ. Иргэд гомдолтой бол очих газар нь тодорхойгүй байдаг бол үүнийг нь тодорхой болгож байгаа. Харин зохицуулагч байгууллагууд бол макро түвшнийхээ асуудлуудаа зохицуулаад байгууллагуудаа илүү зохицуулах. Энэ хуулиар бол яг иргэнд эрхийг нь хамгаалах ийм маргаан таслах байгууллага бий болж байгаа юм гэдгийг хэлье. Финтектэй холбоотой, тэгээд хоршоотой холбоотой асуудлууд дээр нэмэлтээр ажлын хэсэг нэмж хариулъя аа.

Б.Заяабал: Ажлын хэсгийн микрофон хэдэн номер вэ гараа өргөөрэй. 4 номер.

Г.Энхтайван: Мандхай гишүүний асуултад хариулъя энэ хоршоо болон бусад ААН-үүд тэнд хамрагдах юм уу гээд асууж байна. Энэ дээр бүгдээрээ хамрагдана. Тухайн үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас авч үйлчилгээ авч байгаа иргэд ААН бүгдээрээ орж байгаа. Энэ дээр хоршоо ч орно, хувь хүн ч орно, ААН ч орно, бүгдээрээ орж байгаа. Зохицуулагч байгууллага бол санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах өөрийн нэгжтэй байна. Энэ дээр нэгж нь олон нийтийн санхүүгийн боловсролыг түгээх дээшлүүлэх үүрэг хүлээж байгаа энэ хуулиар. Мөн хуулиар ямар ямар мэдээллийг заавал олгох ёстой, хэрэглэгчид заавал таниулсан байх ёстой гэдэг зохицуулалтуудыг оруулж өгч байгаа. Хяналт шалгалтын нэгж байх ёстой тийм даатгалтай болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчтэй яаж ажиллах талаар СЗХ хариулчих уу?

Б.Заяабал: 3 номерын микрофон нээе, нэг минут.

Т.Цэрэнбадрал: Даатгалын компаниудын хувьд даатгалын гэрээний нөхцөл хариуцлага нөхөн төлбөр олгох нөхцөлүүдээ санхүүгийн хэрэглэгчид тодорхой тайлбарлаж байх ёстой. Энэ хуульд заасны дагуу даатгалын ялангуяа нөхөн төлбөр олгохгүй байх хасагдуулга хийх нөхцөл төслийг зайлшгүй санхүүгийн хэрэглэгчид танилцуулж гарын үсэг зуруулж авч байхаар зохион байгуулж байгаа. Мэдээж цар тахал байгалийн гамшигтай холбоотой эрсдэлээс үүсэж байгаа даатгалыг мэдээж тухайн гэрээний нөхцөлийнхөө дагуу зохицуулаад явахаар оруулсан явж байгаа.

Б.Заяабал: Нэмэлт тодруулга юм уу? 4 номер нэмэлт тодруулга.

Г.Энхтайван: Гишүүн түрүүн тэр нэг улирлын шинж чанартай бизнес эрхлэгчдийн зээлийг яах юм бэ гээд тэгж байна. Энэ дээр бол тариаланчид малчид

болон бусад эрчим хүчний бизнесийнхэн ч орж байгаа. Тэгэхээр тухайн үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь зээлийн эргэн төлөлтийн хуваарь дээр яг энэ улирлын шинж чанартай бизнесийн онцлогийг харгалзаж үзээд энэ дээр уян хатан байдлаар нөгөө хуваарийг хийх боломжтой байгаад байгаа. Одоо ер нь бол арилжааны банкнууд дээр ингэж хийгдээд явж байгаа. Дийлэнх улирлын чанартай бизнес эрхлэгч нар бол яг орлого олдоггүй сарууддаа төлбөрөө төлөхгүй тийм зохицуулалттай зээлүүд нэлээн байгаа.

Б.Заяабал: Мандхай гишүүний микрофоныг нээе.

М.Мандхай: Байгууллага хоорондын уялдаан дээр ганцхан омбудсмэний асуудлыг дурдаж байх шиг байна. Тэгэхээр өшөө одоо яг бодитой энэ 3 байгууллага үнэхээр хэрэглэгч ингээд гомдол гаргаад шийдвэрлүүлэх гээд явахад хаашаа эхлээд очих юм. Хаана нөгөө нэг асуудлыг шийдвэрлэх вэ? Энэ 3 байгууллага тэгвэл омбудсментайгаа нийлээд ямар яг процесс явагдах вэ гэдэг нь тодорхой уг нь заачихвал уул нь зүгээр санагдаад байгаа юм, 1 дүгээрт.

Хоёрдугаарт энэ хууль дээр би буруу хараагүй бол омбудсмэний удирдах зөвлөлийг Эдийн засгийн байнгын хороо томилох хараат бус байдлыг хангах гэсэн нэг ийм заалт орчихсон яваад байх юм. Тэгээд энэ улс төрийн нөлөөлөл орохгүй байх дээрээс нь өөрөө тогтвортой энэ удирдах зөвлөлийн гишүүд энэ Байнгын хороодоос томилогдох нь өөрөө тогтвортой байх гэдгийг яаж энэ эрсдэлийг жинлэж харж тооцсон бэ? 1 дүгээрт.

Хоёрдугаарт Энэ омбудсмэний байгууллага байгуулагдаад ингээд бүтэц энэ чинь ингээд тодорхой хэмжээний нэг төсөв шаардлагатай болох юм байна аа. Энэ зардлын тооцоон дээр яг бүрэн зардал тусгагдаж чадсан уу?

Б.Заяабал: 4 номерын микрофон.

Г.Энхтайван: Хэрвээ тухайн санхүүгийн хэрэглэгч өөрт нь асуудал тулгараад асуудлаа шийдвэрлүүлэхийн тулд эхлээд үйлчилгээ үзүүлэгч байгууллагадаа хандана. Дарааллын хувьд энийг энэ хуульд заасны дагуу 3 хоногийн дотор шийдвэрлэх үүрэгтэй үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь. Хэрвээ 3 хоногийн дотор шийдвэрлэсэн нь бол тухайн хэрэглэгчийн эрх ашгийг хангаж чадахгүй байна гэж үзэх юм бол омбудсменд хандана. Омбудсмен маань энийг 1 сарын дотор шийдвэрлэх үүрэгтэй. Омбудсменээс гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол иргэний журмаар шүүхэд хандах тийм зохицуулалттай байгаад байгаа. Тэгэхээр бол яг энэ хугацаануудыг нь энэ хууль дээр тавьж өгсөн. Дарааллуудын хувьд бол яг ийм байгаад байгаа. Тэр зардалтай холбоотой асуудлыг Дагаж мөрдөх журмын тухай хуулиар зохицуулж байгаа. Дагаж мөрдөх журмын тухай хуульд заасны дагуу бол одоо энэ омбудсмен байгуулагдаад эхлэлтийн зардлыг бол төв банкнаас зохицуулж өгч байгаа. Мөн энэ хуулийн зохицуулалтдаа орсон. Дараагийн жилүүдэд хэрвээ шаардлагатай тохиолдолд бол төв банк болон улсын төсвөөс нэмж шаардлагатай санхүүжилтийг хийж болно гэж байгаа. Тэгэхдээ ер нь бол ингээд байгуулагдаад явсныхаа дараа бол энэ өөрийн.../минут дуусав/

Б.Заяабал: Хууль санаачлагч Болормаа гишүүний микрофоныг.

Э.Болормаа: Мандхай гишүүний асуултад хариулъя.

Яаж улс төрийн нөлөөнд орохгүй байх вэ тал дээр бид нар нэлээн ярилцаж бодолцож судалж үзсэн. Эхний төсөл дээр Улсын Их Хурлын даргын санал болгосноор гэдэг ийм төсөл явж байсан. Тэр нь бол энгийнээр бодоход Монголбанкны Ерөнхийлөгчийг, СЗХ-ны даргыг бид нар ийм статуст авчирдаг учир их өндөрлөг статус гэж бодлоо л доо. Ингээд бид нар мэргэжлийн хуульч нартай зөвлөөд үүнээс гадна бусад улс орны туршлагыг судлахад яг мэргэжлийн Байнгын хороо нь томилох нь аливаа нэг албан тушаалд нь санал оруулахаас илүү бага улс төрийн нөлөө ордог гэж үзсэн учир энэ нэгд бол засгийн харьяа байж болохгүй гэж үзэж байгаа юм. Яагаад гэвэл иргэдийн эрхийг хамгаалах төлөөллийн байгууллага нэг төрлийн парламентынхаа харьяа байвал илүү зохистой гэж үзээд түүн дотроо нэг даргын саналаар бус мэргэжлийн Байнгын хорооны саналаар байх нь.

Б.Заяабал: Уянгахишиг гишүүний микрофоныг нээе.

Г.Уянгахишиг: Энэ хууль бол ер нь нэлээн удаан яригдсан нэлээн хүлээлттэй байгаа хууль. Тэгээд яах вэ мэдээж хэлэлцээд эхлээд явахаар нэлээн олон асуудлуудыг бид нар илүү тодорхой ойлголттой болж явах байх. Өнөөдөр тодруулж асуумаар байгаа юм гэхээр энэ хууль дээр байгаа гол зохицуулалт бол өөрөө энэ маргаан шийдвэрлэх байгууллага. Үүн дотроо Омбудсмен тэгээд маргаан шийдвэрлэх байгууллагын томилгоо мөн бүтэц, бүрэлдэхүүн удирдах зөвлөлийн бүтэц гэдэг юм яригдаж байгаа. Энэ дээрээс бид нар нэг юмыг анхаарах ёстой нь болохоор яг энэ маргаан шийдвэрлэх байгууллага. Үүнд дотроо омбудсмен бол өөрөө Иргэний хэргийн шүүхэд хянан шийдвэрлэх хуульд заасан анхан шатын шүүхтэй адилхан чиг үүрэгтэй болчхож байгаа байхгүй юу. Өөрөөр хэлэх юм бол яг энэ хуульд заасан зохицуулалтаар 21.6 дээр Нийслэлийн давж заалдах шатын шүүх бол анхан шатаар, Улсын дээд шүүх бол давах шатаар хэлэлцэнэ гэдэг ийм нөхцөл байдалтайгаар ороод ирж байгаа юм.

Тэгэхээр энэ нь өөрөө яг ингээд шүүхийн тогтолцооны хувьд бол яг цоо шинэ байгууллага гараад ирж байгаа. Тэгэхээр энэ тал дээр яг шүүхийн байгууллагаас Улсын дээд шүүхээс, Хууль зүйн яамнаас гэдэг юм уу яг мэргэжилтнүүдээс санал дүгнэлт авсан байдаг уу. Энэ дээр ямар тайлбар ирсэн байдаг вэ гэдгийг мэдмээр байна. Мөн 2 дугаар асуулт бол яг энэ Омбудсмений шийдсэн шийдвэртэй холбоотойгоор зөвхөн санхүүгийн хэрэглэгч гомдол гаргах эрхтэй байгаа. Өөрөөр хэлэх юм бол нөгөө омбудсмений шийдчихсэн асуудал дээр магадгүй тэр санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх ашиг хөндөгдсөн байвал яах вэ гэдэг асуудал үлдчихэж байгаа юм. Өөрөөр хэлбэл шүүхээр шийдвэрлүүлэх тэр эрх нь яах билээ? Шууд ингээд эрхийг нь хаачхаж байгаа нь хэр зохимжтой юм бэ? Энэ дээр тэр яг шүүхийн байгууллагаас авсан хуульчдаас авсан тийм санал дүгнэлт, хууль зүйн дүгнэлт байна уу? Тэрэн дээр ямар тайлбар ирсэн байсан бэ гэдгийг асуумаар байна. Тэгээд яах вэ нөгөө хэрэг маргааны харьяалал дээр нэлээн тодорхой болгож зурж харах шаардлагатай харагдаж байна. Жишээлэх юм бол яг үнийн дүнгээр бол 79200 одоогоороо нөгөө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уячихсан учраас ерөнхийдөө нэг 80 сая хавьцаа хүртэлх маргаан бол орж ирж байгаа юм байна. Энэ дотроо нэг анхаарал татсан заалт бол 19.2.4 дээр Омбудсмен шийдвэр гаргахдаа гомдлын шинж чанар нь шүүхээр шийдвэрлэхэд илүү зохимжтой гэж үзвэл шүүх рүү шилжүүлнэ гэдэг ийм асуудал явж байгаа юм.

Тэгэхээр энэ дээр нөгөө хэрэг маргааны яг харьяалал маань хэр тодорхой нарийн тусгагдаж чадсан бэ? Энэ чинь өөрөө дараа нь нөгөө үл ойлголцол хүлээлтийн зөрөө үүсэх юм биш биз дээ гэдэг ийм нэг асуултууд байна.

Б.Заяабал: Ажлын хэсгийн хэддүгээр микрофон бэ? 4 дүгээр микрофон нээе.

Г.Энхтайван: Хуулийн төслийг бид бүхэн Улсын Их Хурлын гишүүдтэй хамтран боловсруулах явцад бол хэд хэдэн асуудлуудыг захиргааны ШЕЗ-тэй хамтран асуудлуудыг шинэчилсэн. Энэ нь бол маргаантай холбоотой асуудал. Захиргааны хэргийн шүүх рүү явах байсан энийг ШЕЗ-тэй ярилцсаны үндсэн дээр Иргэний хэргийн шүүх рүү явахаар болж байгаа. Тэгэхээр омбудсменээс давсан дараагийн шат нь бол иргэний хэргийн шүүх дээр хүн өргөдөл гаргаад асуудлаа шийдвэрлүүлээд явна. ШЕЗ бол энэ омбудсмений буюу маргаан таслах энэ байгууллага байгуулах асуудлыг дэмжиж байгаа. Энэ нь бол нэг талаасаа эвлэрүүлэн зуучлахтай ер нь ижил төсөөтэй. Мөн шүүхийн байгууллагын ачааллыг бууруулж шүүхийн байгууллага өөрөө ихэвчлэн үнийн дүн өндөртэй юм уу ач холбогдол өндөртэй тийм томоохон хэргүүд дээр цаг заваа зарцуулах энэ боломжийг нээлттэй болгох боломжийг бий болгож өгч өгч байгаа.

Тэгэхээр бол ингээд илүү жишээлбэл бодит практик дээр жолоочийн хариуцлагын даатгалтай холбоотой нөхөн төлбөртэй холбоотой асуудал бол урьд нь шүүхийн шатад шийдэгддэг байсан бол энэ омбудсменээр Маргаан таслах зөвлөлөөр ороод явж байгаа нь илүү одоо юу гэдэг юм мэргэжлийн байгууллагаар шийдүүлж байгаа гэсэн тийм зохицуулалтыг оруулж ирж байгаа юм. Харьяалал дээр энэ иргэний хэргийн шүүхээр явж байгаа. Хэрэг маргааны харьяаллын хувьд.

Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь гомдол гаргах эрхгүй. Энэ дээр бол яах вэ хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж байгаа гэж үзэж байгаа. Нөгөө талаасаа тэнцвэртэй байна гэж үзэж байгаа. Мэргэжлийн байгууллага нь өөрөө энэхүү салбарт олон жил ажилласан мэргэжлийн үйл ажиллагаа явуулсан, харьцангуй туршлагатай байгаа учраас тийм тэнцвэртэй юу гэдэг юм хуулийн өмнө тэнцвэртэй байлгах үүднээс мэргэжлийн оролцогчийг нь бол шүүхэд гомдол гаргах эрхгүй байхаар энэ дээр зохицуулсан. Олон улсын практикийн хувьд ч гэсэн юм байгаа.

Б.Заяабал: Хууль санаачлагч Болормаа гишүүн нэмэлт өгөх гэж байна уу? Нэмэлт нэг минут өгчихье.

Э.Болормаа: Уянгахишиг гишүүн маань их чухал яг хууль эрх зүйн шинж чанартай асуултуудыг асуулаа. Би эндээс нэг зүйлийг л тодруулж хэлэх гэсэн юм. Бид нар энэ нэг талдаа мэргэжлийн байгууллага, нөгөө талдаа иргэн байгаа. Тэгээд үндсэн нөгөө зорилго маань энэ 2-ын тэнцвэргүй харьцааг илүү тэнцвэржүүлэх. Олон улсын судалгаан дээр бол ер нь энэ судалгаанд Дэлхийн банкны энэ дэлхийн санхүүгийн хүртээмж ба хэрэглэгчийг хамгаалах тогтолцооны өнөөгийн байдал гэсэн энэ тайланд бол 113 улсаас 63 нь буюу 56 хувь нь санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тусгай бие даасан хуультай байна гэж байгаа юм. Энэ дунд бол сайн тогтолцоо гэж юуг хэлж байна вэ гэхээр 5 үндсэн зарчим байгаа. Ил тод байдал, чөлөөт сонголт хийх боломж, гомдол шийдвэрлэх механизм бид нарын оруулж ирж байгаа энэ омбудсмен нь мэдээллийн нууцлал санхүүгийн боловсрол. Эдгээр бусад улсын туршлага ч гэсэн энэ 2-ыг илүү тэнцвэртэй байлгахын тулд байгууллагын энэ эрхийг хязгаарладаг юм байна лээ.

Б.Заяабал: Нэмэлт авах уу? Анар гишүүн микрофон нээе.

Ч.Анар: Санхүүгийн хэрэглэгчийн үйлчилгээ үзүүлэх эрхийг хамгаалах тухай хуулийг бол дэмжиж байгаа. Энэ бол нэн шаардлагатай байгаа хууль гарцаагүй. Энэ дээр 2 асуулт байна, нэгдүгээрт энэ Мандухай гишүүн асууж байна. Уянгахишиг гишүүн асууж байна. Энэ Маргаан шийдвэрлэх удирдах зөвлөлийн томилгоог Эдийн засгийн байнгын хороо хийнэ гэдэг чинь өөрөө улс төрийн нөлөөлөлтэй томилгоо болох гээд байна. Дахиад энэ заалт дотроо Эдийн засгийн байнгын хороо чинь томилгоо хийнэ. Цалин төсвийн журмыг нь батална гэж байна. Тэгэхээр би энэ асуултыг нөгөө ажлын хэсгээс биш Эдийн засгийн байнгын хорооны дарга, ахлах зөвлөхөөс асууя.

Манай улсад ийм жишиг байдаг юм уу? Та ерөнхийдөө бол энэ бүтцээр Маргаан шийдвэрлэх удирдах зөвлөл гэдэг чинь нэг төрлийн шүүх болж байна. Шүүгч томилдог дарга болох гэж байна шүү дээ. Ер нь бараг Ерөнхий шүүгч болох гэж байна шүү дээ Эдийн засгийн байнгын хорооны. Тэгэхээр энэ хууль зүйн хувьд ийм жишиг байдаг юм уу? Дүгнэлттэй юм уу?

Хоёрдугаарт ажлын хэсгээс асуух гэж байгаа юм нь сая Уянгахишиг гишүүн асууж байна. Энэ сая Болормаа гишүүний хууль санаачлагчийн тайлбарыг сонслоо танилцлаа. Үйлчилгээ үзүүлэгч нь өөрөө маргалдах эрхгүй байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн иргэн, хуулийн этгээд ижил тэгш эрхтэй байна гэсэн заалттай зөрчилдөх үү? Энэ дээр хууль зүйн дүгнэлт байгаа юу? Энэ 2 асуултад хариулт авъя аа.

Б.Заяабал: Ажлын хэсэг эхлээд хариулчих уу? 4 номерын микрофон. Дараа нь нэмэлт өгье.

Г.Энхтайван: Монгол Улсын Үндсэн хууль дээр иргэн бүр хуулийн өмнө тэгш эрхтэй байна гэсэн хуулийн зохицуулалт байгаа. Түүнээс биш ААН гэдэг ойлголт байхгүй. Энэ мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой зохицуулалт оруулж байгаа. Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нь тэгэхдээ тухайн юу гэдэг юм тодорхой хэмжээнээс давсан тохиолдолд мэдээж шүүхэд давж заалдах нь нээлттэй байгаа л даа. Хууль дээр байгаа 80 сая төгрөгөөс дээш хэмжээний юу гэдэг юм асуудал дээр тухайн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нь иргэний хэргийн шүүхэд хандаад явах нь нээлттэй байгаа. Түүнээс доошхыг хэрэглэгчийн талд шийдвэр гэхээр зохицуулсан байгаад байгаа. Олон улсын жишиг яг ийм байгаа. Жишээлбэл 400 хэд билээ? 450 мянган паундаас дотогш давж заалдах эрхгүй байгаад байгаа. Ер нь бол дэлхийн дийлэнх орнууд яг энэ дээр тухайн улс орныхоо онцлогтоо хамааруулаад нөгөө босго тавиад босго дотор санхүүгийн хэрэглэгчийн талд давж заалдахгүй байхаар зохицуулалттай. Түүнээс давсан тохиолдолд мэргэжлийн оролцогч нь өөрөө шүүхэд хандах эрхтэй байгаа. Манай дээр ийм зохицуулалт байгаа.

Б.Заяабал: Гишүүний асуусан асуултад хариулъя аа.

Тэгэхээр эдийн засгийн энэ өргөн барьсан хуулийн төслөөр аваад үзэх юм бол энэ Эдийн засгийн байнгын хороо Улсын Их Хурлын нөгөө бүрэн эрхийг хэрэгжүүлэх, албан тушаалыг томилох, албан тушаалтныг томилох ийм асуудал орж ирээд байгаа юм. Тэгээд хууль зүйн хувьд аваад үзэхээр зэрэг Улсын Их Хурлын энэ хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлд Улсын Их Хурлаас томилох албан тушаалтныг нэр зааж тодорхой өгсөн байдаг. Уг хуулийн төсөл дээр яг энэ Улсын Их Хурлын энэ Хяналт шалгалтын тухай хуулийн яг уг заалтад нэмэлт,

өөрчлөлт оруулахаар уг хуулийн төсөл дагалдаж өргөн баригдаагүй ийм зүйл ажиглагдаж байгаа.

Дээрээс нь бас энэ хуулийн төсөлтэй холбоотой Засгийн газраас ирүүлсэн санал дээр энэ омбудсмений талаарх зохицуулалт нь болон энэ шүүхэд маргаан шийдвэрлэх асуудлууд нь хууль зүйн зөрчилтэй байж болзошгүй гээд ийм Засгийн газраас ирүүлсэн санал дээр бичигдчихсэн байгаад байгаа юм. Тийм учраас би бол хувь гишүүнийхээ хувьд бол энэ Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 35.4-д заасны дагуу Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай энэ хуулийн төсөлд Улсын Их Хурлын Тамгын газрын дүн шинжилгээ хийлгэх хууль зүйн зөвлөмж гаргуулах ийм нэг горимын санал гаргая гэсэн ийм бодолтой л байгаа гэдгийг хэлчихье. Тэгээд асуулт хариулт дууссаны дараагаар энэ горимын саналыг гаргая гэж бодож байна.

Болормаа гишүүн нэмэлт тайлбар хэлье нэг минут өгье.

Э.Болормаа: Байнгын хорооны даргадаа баярлалаа. Байнгын хорооны даргатай бас нөгөө хурлын өмнө уулзахад яг 2 асуудлыг хөндсөн тэгээд түүнийг тодруулсан байгаа. Яг энэ Засгийн газрын хэлээд байгаа санал зөрчилдөөн гээд байгаа зүйл нь бид нар өмнө нь нөгөө Засгийн газраас санал авах хувилбар дээр Захиргааны хэргийн гэж орсон байсныг харин яг энэ Засгийн газрын саналыг аваад Иргэний хэргийн шүүх болгосон юм. Тэгэхээр энэ саналыг нь авсан байгаа. Тэр ямар нэгэн нөгөө зохицолдохгүй байгаа гэсэн зүйлсийг нь бид нар шийдсэн гэсэн үг. Нөгөө яриад байгаа зүйлийг нь сая Энхтайван дэд ерөнхийлөгч яг хариуллаа. Энэ Үндсэн хуулийн гээд байгаа зүйл бол иргэн бүр хуулийн өмнө тэгш эрхтэй гэж байгаа болохоос биш 7 буудлын Должин эмээ, Хаан банк 2 байгууллагынхаа хувьд ижил тэгш эрхтэй гэж Монгол Улсын Үндсэн хууль заадаггүй байгаа.

Тэгэхээр тэр агуулга ороогүй гэж үзэж байгаа. Бид нар энэ дээр дүгнэлт хийх шаардлагагүй гэж үзэж байгаа.

Б.Заяабал: Хуралдааны дэгийн дагуу гишүүд асуулт асууж дууслаа.

Би саяын үндсэн асуудлаар бас горимын санал гаргачихъя гэж ингэж бодож байна. Өөрөөр хэлбэл энэ омбудсмений асуудал нь өөрөө 1 дүгээрт саяын ярьсан асуудлаар Эдийн засгийн байнгын хороо шууд Улсын Их Хурлын бүрэн эрхийг бүрэн хэрэгжүүлээд шууд ингээд Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан томилох албан тушаалтны нэр зааж уг хуулийн төсөл дээр дагалдаж нэмэлт, өөрчлөлт орох ийм хуулийн төсөл боловсруулагд болоогүй байгаа.

Хоёрдугаарт нь энэ омбудсмений зохицуулалт нь шүүхийн маргаан шийдвэрлэх асуудлууд нь хууль зүйн зөрчилтэй байж болзошгүй гэсэн ийм 2 асуудлаар Улсын Их Хурлын Тамгын газраас дүн шинжилгээ хийлгэх хууль зүйн зөвлөмж гаргуулах ийм горимын саналыг би гаргаж байна аа.

Ингээд мэдээж энэ горимын санал, санал хураалтаар Байнгын хорооны гишүүдийн олонхын саналаар шийдэгдээд явна аа. Улсын Их Хурлын Тамгын газраас дүн шинжилгээ хийлгэх, хууль зүйн дүгнэлт авах ийм шаардлага байна гэж ингэж үзэж байгаа. Тэгээд энэ хувь гишүүний хувьд ийм горимын санал гаргаж байна. Горимын санал гаргах уу, шууд санал хураах уу?

Горимын санал гаргасантай холбоотойгоор гишүүдийн санал хураалт явуулах дэгтэй тул Байнгын хорооны гишүүдийг хуралдааныхаа танхимд хүрэлцэн ирэхийг урья. Саяын гаргасан горимын санал тодорхой байгаа.

Тэгээд горимын саналыг санал хураалтад горимын саналаар санал хураалтад бэлтгэе. Гишүүдийг санал хураалтад бэлтгэхийг хүсье.

Гаргасан горимын саналыг дахиж унших уу гишүүдэд.

Өөрөөр хэлбэл энэ өргөн барьсан хуулийн төсөл нь омбудсмений талаарх зохицуулалт нь шүүхэд маргаан шийдвэрлэх асуудлууд нь хууль зүйн зүйд зөрчилтэй байж болзошгүй гэж Засгийн газраас ирүүлсэн санал, мөн дээрээс нь Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлд байгаа Улсын Их Хурлаас томилох албан тушаалтны нэр зааж тодорхой тусгасан байдаг. Энэнтэй холбоотойгоор уг хуулийн төсөлд Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал цуг өргөн баригдаагүй байна. Ийм учраас хуралдааны дэгийн тухай хуулийн 35.4-д заасны дагуу Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөлд Улсын Их Хурлын Тамгын газраас дүн шинжилгээ хийлгэх, хууль зүйн зөвлөмж гаргуулах горимын саналаар санал хураалгая.

Санал хураалт.

Горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

30.4 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй ээ.

Ингэхээр дэгийнхээ дагуу хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан одоо дэмжсэн дэмжээгүй байраа илэрхийлж үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Байхгүй байна.

Үг хэлэх гишүүд байхгүй учраас Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 35.11 дэх хэсэгт заасны дагуу хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх талаар санал хураалт явуулъя аа.

Гишүүдийг санал хураалтад бэлтгэхийг урья.

Санал хураалтын томьёоллыг уншъя аа.

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

56.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Одоо хамт өргөн мэдүүлсэн:

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд бэлэн үү.

Санал хураалт.

56.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн. Томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

60.9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

4.Хамт өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

60.9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

5.Хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Хамт өргөн мэдүүлсэн Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

60.9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал танилцуулна аа.

Өргөн барьсан гишүүн болохгүй юу? Уянгахишиг гишүүн танилцуулна аа.

Хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудалд оръё оо.

Гурав.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал, Ч.Анар, Ц.Мөнхбат, Л.Соронзонболд, Ж.Галбадрах нарын 5 гишүүнээс Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэх

Улсын Их Хурлын гишүүн Золжаргал, Анар, Мөнхбат, Соронзонболд, Галбадрах нарын 5 гишүүнээс Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэж эхэлье ээ.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны ТНБД Бавуужавын Мягмарнаран. Мягмарнаранг асуулгын хариуг танилцуулахыг урьж байна. Ажлын хэсгийн микрофоныг нээе. Ажлын хэсгийг мөн оруулья аа.

Ажлын хэсгийн 5 дугаар микрофон нээе.

Б.Мягмарнаран: Сайн байцгаана уу? Мэдээлэл технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн талаар танилцуулгыг хийхээр Цахим хөгжил, харилцаа холбооны яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Мягмарнаран хийж байна аа. Хуультай холбоотой хуулийн товчхон танилцуулгыг та бүхэнд хүргэе.

Мэдээлэл технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль маань 2024 оны 6 сарын 5-ны өдөр батлагдсан байдаг. 2024 оны 9 сарын 25-ны өдөр хуульд заасан Мэдээллийн технологи үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх Үндэсний зөвлөлийг байгуулж ажиллах журмыг Засгийн газрын 97 дугаар тогтоолоор батлуулсан байдаг.

Б.Заяабал: Микрофон жоохон чангалах уу? Жоохон ойртоод ярих уу? Ямархуу байна? Үүнтэй холбоотой мөн 2025 оны 4 сарын 4-ний өдөр Мэдээлэл технологийн үйлдвэрлэл дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг Үндэсний зөвлөлийн 3 дугаар тогтоолоор баталсан.

2025 оны 5 сарын 9-ний өдөр харилцаа холбоо мэдээлэл технологийн салбарт ААНОАТ-ын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагааны тавигдах шаардлагыг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 79 дүгээр тушаалаар баталсан. Энэ нь болохоор тухайн хуулийн 22.9 дэх заалтын хэрэгжилтийг хангаж хийсэн байдаг. Мөн тус оны 9 сарын 17-ны өдөр Засгийн газрын 98 дугаар тогтоолоор мэдээлэл технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажиллах журам, мөн виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээд үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журмыг баталсан.

2026 оны 1 сарын 1-ээс мэдээлэл, технологийн үйлдвэрлэлийг дэмжих, виртуал бүсэд бүртгэх, хуулийн этгээдийн бүртгэлийг ebusines платформоор цахимаар бүртгэж авах процесс эхлээд одоогоор 98 компани хүсэлтээ илэрхийлчихсэн явж байна.

Дараагийн слайд дээр бид бүхэн виртуал бүсийн үйл ажиллагаанд ямар процессын дагуу ААН бүртгүүлж явах вэ гэдэг процессыг товчхон оруулсан байгаа. Хуулийн этгээд нь өөрөө холбогдох заасан бичиг баримтыг бүрдүүлж, ажлын алба, виртуал бүсийн ажлын алба буюу Мэдээлэл технологийн үндэсний паркт материалаа хүргүүлнэ. Мэдээлэл технологийн үндэсний паркаас холбогдох шаардлагын дагуу материалыг шалгаад шаардлагатай нэмэлт материал байгаа. Ажлын 3 хоног дотор хүлээж авна. Авсан материалынх нь дагуу хэрвээ шаардлага хангаж байх юм цахим гэрээ байгуулах. Цахим гэрээ байгуулсны дараа ААН-ийн Виртуал бүсэд бүртгэлийг баталгаажуулаад Татварын ерөнхий газарт бүртгүүлснээр энэ бүртгэл маань бүртгэгдэх процесс маань явах юм.

Дараа нь бол бүртгэгдсэн ААН дээр хяналтыг жил бүрийн 3 сард гүйцэтгэхээр хуульд заасан байдаг.

Хяналтаар бол бид нар санхүү татварын тайлан гэрээний хэрэгжилтийн болон нийгмийн даатгалын.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 5 дугаар микрофоныг нээе.

Б.Мягмарнаран: Танилцуулга бүрэн дуустал нээж өгье. Тэгээд бүртгэлийг хийж явах процесстойгоор заасан байдаг аа. Хуульд хамгийн гол нь заасан зүйл бол төрөөс үзүүлэх дэмжлэгийг татварын болон татварын бус дэмжлэгийг үзүүлнэ гэж заасан. Хуулийн 13.2 дээр виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд үзүүлэх татварын дэмжлэгийг холбогдох хуульд заасны дагуу үзүүлнэ гэсэн байдаг. Энэ нь болохоороо ААНОАТ-ын хууль дээр хөнгөлөх ангиллын 22.5.4, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдийн албан татварыг хөнгөлнө өө гэсэн заалт байгаа. Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх 9 төрлийн татварын бус дэмжлэг үзүүлнэ гэж зааж өгсөн байгаа. Энэ хуульд заасан 9 төрлийн хөнгөлөлтийг энэ танилцуулга дээр оруулсан байгаа.

Энэнд ерөнхийдөө бол гранд хэлбэрээр шинэ инновац нэвтрүүлсэн байх юм бол холбогдох байгууллагад патентжуулах зардлыг гранд хэлбэрээр олгох, экспортод чиглэсэн мэдээлэл технологийн бүтээгдэхүүн байх юм бол олон улсын стандарт чанар баталгаажилтыг авсан тохиолдолд бүхэлд нь эсвэл хэсэгчлэн гранд олгох, мэдээлэл технологийн үйлдвэрлэл эрхлэгчийн төлсөн НДШ-д нөхөн олговор олгох, хиймэл оюун ухаанд суурилсан гээд дэвшилтэт технологид суурилсан төсөл арга хэмжээний нийт өртгийн 60 хувь болон түүнээс дээш хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн тохиолдолд үлдсэн хувьд нь гранд олгох дэвшилтэт технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгосон патент эзэмшигч шагнал урамшуулал олгох зэрэг ийм 9 төрлийн татварын бус дэмжлэгийг хуульд зааж өгсөн байдаг. Татварын бус дэмжлэгийн энэ дээр нэг гол асуудал нь болохоороо санхүүжилтийн эх үүсвэрийг тогтоох ёстой байгаа.

Санхүүжилтийн эх үүсвэр дээр хуулийн 14.1 дээр виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдэд үзүүлэх дэмжлэг нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ гэж байгаа. Тэгэхээр энэ 14.1.1 дээр мэдээлэл технологийн үйлдвэрлэлээс төсөвт төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн 40-өөс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө, 14.1.2 дээр гадаад улс ОУБ түүнчлэн дотоод гадаадын ААНБ, иргэнээс өгсөн хандив тусламж, 14.1.3 дээр тухайн хуулийн 7.4-д заасны дагуу төсвийн байгууллагын өөрийн эзэмшиж байгаа программ хангамжийн эх кодыг гадаад улсад

ашиглуулснаас олсон орлого, 14.1.4 дээр Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.5, 5.3.18, 5.3.20-д заасан сангуудаас 5-аас доошгүй хувийг виртуал бүсийн дэмжлэгийн санхүүжилтийн эх үүсвэр болгоно оо гэж заасан байдаг.

Тэгээд тулгарч байгаа гол асуудал юу вэ гэхээр бид нарын хувьд хамгийн тулгар гарч байгаа зүйл бол санхүүжилтийн эх үүсвэрийн асуудал байгаа. Сая дурдсан хуулийн 14.1.4 дээр Засгийн газрын тусгай сангаас 5-аас доошгүй хувийг нэр дурдсан тусгай сангаас 5-аас доошгүй хувиар дэмжлэгийн эх үүсвэрийг бүрдүүлнэ гэж заасан байдаг. Энэ 3 сан нь юу вэ гэхээр ШУТС, хөдөлмөр эрхлэлтийн сан, ЖДҮ-лэлийн сан багтана.

Тэгэхээр энэ дээр хамгийн том асуудал нь юу вэ гэхээр тухайн сангууд дээр өөрийнхөө хуулиар сангаасаа өөр санд шилжүүлэх зохицуулалт ерөөсөө байхгүй. Д

араагийн нэг хүндрэлтэй юм нь жишээ нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ажил үйлчилгээг дэмжих сургалт зохион байгуулахаас бусад төрлийн дэмжлэг үзүүлэх боломжгүйгээр хуульчилчихсан.

Тэгэхээр нөгөө энэ 2 сангийн уялдаа холбоо байхгүй байгаад байгаа. Шинжлэх ухаан технологийн тухай хуульд үндэсний ШУТС-аас аливаа төрлийн дэмжлэг, татаас олгохгүй бөгөөд зөвхөн эргэн төлөгдөх зээл өгөхөөр заасан тул зохицуулалт зөрчилддөг асуудал байгаад байгаа. Мөн ЖДҮ-лэлийг дэмжих сан нь хөнгөлөлттэй зээл хэлбэрээр олгогддог. Тэгсэн хэрнээ 2020 оноос хойш төсвөөс мөнгө огт тавигдаагүй. Тэгээд үүнээс үүдээд нөгөө эргэн төлөлтөөр тухайн жилд ирсэн хүсэлтийн 20 хувийг л ерөнхийдөө шийдвэрлэдэг юм байна лээ. Тэгээд нөгөө эх үүсвэр байхгүйгээс төсөвт одоо энэ сангийн үйл ажиллагаан дээр зардал мөнгө хуримтлуулж чадахгүй байгаад байгаа. Улсын төсөвт мэдээлэл технологийн үйлдвэрлэлээс төвлөрүүлж буй мөнгөн хөрөнгийн хэмжээг тооцоход хүндрэлтэй. Бид бүхэн өнгөрсөн хугацаанд 2026 онд 8.5 тэрбумын саналыг хүргүүлсэн боловч батлагдаагүй. 2027 онд бид бүхэн 20 тэрбумын саналыг өгсөн байгаад байгаа юм.

Тэгээд энэ маань өөрөө нөгөө Төсвийн тухай хуулийг өргөн баригдах үеэр Сангийн яамнаас дэмжигддэггүй ийм асуудал байгаад байгаа юм. Татварын бус дэмжлэг олгох асуудал дээр нэг том асуудал байгаа нь татварын бус дэмжлэгийг олгох хувь хэмжээ түүнтэй холбоотой зохицуулалт тодорхойгүй.

Тухайлбал НДШ-ийг нөхөн олговор олгоно оо гээд заачихсан байдаг. Гэтэл нийгмийн даатгалын нөгөө шимтгэлийн нөхөн олговрын талаарх зохицуулалт нь Нийгмийн даатгалын тухай хууль дээр огт байдаггүй. Өөрөөр хэлбэл нөхөн олговор гэсэн ойлголт байдаггүй болохоор энэ заалт өөрөө хэрэгжих боломжгүй болчихоод байгаа юм.

Татварын бус дэмжлэгийн санхүүжилтийг бүрдүүлэх асуудал дээр түрүүн дурдсан асуудлууд гараад байгаа.

Нэгд нь болохоор бид бүхэн яг энэ талаар бол Засгийн газрын 2026 оны 36 дугаар тогтоолоор Мэдээлэл технологийн үйлдвэрлэлийн дэвшилтэт технологи хөгжүүлэх үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэмэлт, өөрчлөлт оруулж шинэчлэн батлуулсан. Өргөтгөсөн хуралдааныг 2026 оны 4 сарын 21-ний өдөр байгуулж тулгамдаж байгаа асуудлыг Үндэсний зөвлөлийн тэргүүн Ерөнхий сайдад танилцуулсан.

Энэ дээр бид нар тулгамдаж байгаа асуудлын хүрээнд бол хэд хэдэн асуудлыг танилцуулаад Засгийн газар Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байдаг.

Нэг дэх нь болохоор мэдээлэл технологийн үйлдвэрлэлийг дэмжихэд шаардлагатай улсын төсвийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээг тодорхойлж, 2027 оны улсын төсвийн төсөлд тусгах шийдвэрлүүлэх хүсэлтээ бид нар илэрхийлсэн байгаа. Нөгөө түрүүн дурдсан 3 тусгай сангийн санхүүжилтээр тухайн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөөд 5-аас доошгүй хэмжээний хөрөнгө хувийг бол тусгаж батлуулах саналаа өгсөн. Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх мэдээллийн болон дэвшилтэт технологи, инновац шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болоход шаардлагатай тоног төхөөрөмж, эд анги, бүрэлдэхүүн хэсэг, дэд угсралтын хэсэг, сэлбэг, холбогдох хэрэгслийн жагсаалтыг шинэчлэн боловсруулах дээр санал өгөхөөр бид бүхэн ажиллаж байна. Энэ нь болохоор ГЕГ дээр байгаа заалт. Тэгснээрээ бид бүхэн нөгөө гаалийн хөнгөлөлт оруулж ирж байгаа мэдээлэл технологийн үйлдвэрлэлийг дэмжих шаардлагатай тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлөх агуулга энэ дээр явж байгаа.

Дараагийнх нь болохоор Мэдээлэл, технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд заасан татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэхтэй холбоотой бусад хуульд оруулж хуульд өөрчлөлт оруулж байж энэ цогцоороо шийдэгдэх юм байна гэж харсан. Үүний хүрээнд бид бүхэн сая Татварын багц хууль дээр бид бүхэн 4 саналыг хүргүүлж ААНОАТ-ын хууль бусад Хувь хүний орлогын татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд саналаа хүргүүлсэн. Гэхдээ хуулийн төслийг Сангийн яам холбогдох байгууллагаас өргөн барихдаа зөвхөн ийм 2 агуулга л бид нарын өгсөн саналаас тусгагдсан байгаа.

Нэгд нь болохоороо их хэмжээний өгөгдлийг өндөр хурдтай хадгалах автоматаар боловсруулах зориулалттай тоног төхөөрөмж график процессор буюу сервер супер компьютерын элэгдэл хорогдол тооцох хугацааг 3 жил болгохыг бол нэмж оруулахаар болсон.

Хоёр дахь нь болохоороо мэдээлэл технологи, үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдийн үйл ажиллагааны орлогод ноогдох албан татварыг хөнгөлөхөөр оруулж өгсөн байгаа.

Тэгээд ерөнхийдөө бол бид нарын өгсөн саналууд хангалттай. Шинэ хуулийн татварын багц хууль дээр тусгагдаагүй гэсэн үг. Нэг иймэрхүү хэрэгжилттэй байна. Танилцуулж дууслаа. Баярлалаа.

Баярлалаа.

Б.Заяабал: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113.1.2, 3.4-т заасны дагуу асуулга тавьсан гишүүд тусдаа асуулт уг авах эрх байгаа. Ингээд дэгийн дагуу асуулга тавьсан гишүүдээс бусад гишүүд уг асуулгатай холбоотойгоор асуулт асуух гишүүд нэрсээ өгөхийг хүсье ээ. Алга байна.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113 дугаар зүйлийн 113.1.2-т заасны дагуу асуулга тавьсан Улсын Их Хурлын

гишүүн асуулт асуух уу? Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд асуулгын хариутай холбогдуулан асуулт асуухыг урья.

Соронзонболд гишүүний микрофоныг нээе.

Л.Соронзонболд: Энэ тайлан дээр байсан юм аа. Энэ ЗГХЭГ-аас 2024 онд Дорнод, Хөвсгөл аймагт хэрэгжүүлсэн тус бүр 10 тэрбум төгрөгийн программ хангамж тавигдсан байна лээ. Тэр яг ямар ажлууд байсан бэ? Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөөч? Эдийн засаг хөгжлийн яамнаас хүн байгаа билүү? Эдийн засаг хөгжлийн яаман дээр энэ BPS гээд программ ашиглалт, сайтын ашиглалт болон энийг болохоор нөгөө бусад төсвийн ерөнхийлөн захирагч нар ашиглаж нэгдсэн удирдлагатай болгох асуудал ерөөсөө хангалтгүй байна гэсэн ийм аудитын дүгнэлт гарсан юм байна лээ. BPS.mn, mof.gov.mn гэсэн ийм сайт болон энэ системийг ашиглахтай холбоотойгоор бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарын ашиглаж байгаа байдал энийг нэгдсэн удирдлагаар хангаж байгаа байдал хангалтгүй байна гэсэн ийм дүгнэлт Аудитын үндэсний аудитын тайлан дээрээс энэ талаар мэдээлэл өгөөч гэдэг ийм 2 асуулт байна.

Б.Заяабал: Ажлын хэсэг. Засгийн газар талаас хэдэн номерын микрофон. 3 номерын микрофоныг нээе. Гишүүний асуултад хариулъя.

Б.Мягмарнаран: Гишүүний асуултад хариулъя. ЗГХЭГ-ын Мэдээлэл, технологийн газрын дарга Билигдэмбэрэл.

Тэгэхээр гишүүний хувьд асуултад асуусан яг энэ 8 тэрбум төгрөгтэй холбоотой мэдээлэл бол одоогоор надад байхгүй байна.

Тэгэхээр тусгайлан яг ийм мэдээллийг би тусад нь гаргаж хүргүүлэх нь зөв болох байх. Яг одоогоор ийм мэдээлэл алга байна. Албан бичгээр дэлгэрэнгүй хариултыг Соронзонболд гишүүн рүү хүргүүлээрэй. Ажлын хэсэг өөр асуулт асуух гишүүн байна уу? Золжаргал гишүүн асуух уу? Ингээд гишүүд асуулт асууж дууслаа. Эрдэнэбат гишүүний микрофоныг нээе. Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Энэ мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих гээд сая бид нар чинь нэг хүүхэд нүхэнд унаад тэгээд үндсэндээ энэ хүүхдийн аюулгүй байдалтай холбоотой нэг аппликэйшн нийслэлийн хэмжээнд улсын хэмжээнд энэ хийе гээд бараг 2 жилийн өмнө би бас тодорхой санал өгч байсан юм. Программ хангамжийнх нь зардал үсрээд 30, 40 сая төгрөгийн хэмжээнд л байсан юм. Тэгэхээр ийм нийгэмд хэрэгцээтэй магадгүй ашгийн төлөө бус иймэрхүү программ хангамж, мэдээллийн технологийн энэ үйлдвэрлэлийг дэмжихэд энэхүү санд хуримтлуулаад хийх хэрэгтэй юм шиг байгаа юм.

Тэгэхээр энэ тал дээр яг ийм бодлого байна уу? Одоо энэ дээр бол нийт Мэдээллийн технологийн үйлдвэрлэл дэмжих тухай хууль дээр мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс төсөвт хүргүүлсэн 40-өөс доошгүй хувь тэнцэх хэмжээний хөрөнгийг төвлөрүүлнэ гэж байна.

Тэгээд энэ мөнгийг нийтийн үүргийн сан болгоод нийгэмд хэрэгцээтэй ийм чухал ийм программ хангамжуудыг хийгээд сая л нөгөө осол аваар гараад хүүхэд эндээд тэгээд энэ олон нийтийг оролцуулсан мэдээлэл бүртгэх, хянах, аюул ослыг арилгах гэдэг л нэг ийм программ хангамж хийе л гэж нэг дуугарлаа л даа. Тийм

учраас яг энэнтэй ижилхэн дахиад нийтийн аюулгүй байдалтай холбоотой программ хангамжийг хөгжүүлэх тал дээр энэ ямар бодлого байна вэ?

Дахиад нийтийн хэрэгцээнд шууд ашиг гэж харахаасаа илүүтэй нийгмийн үүргийн сангаар хийгдэх ийм программ хангамж, магадгүй малдаа төөрсөн хүмүүс ч байдаг юм уу. Зуд турхан болдог өвчин зовлон гардаг болзошгүй аюул ослоуд гаргахаас урьдчилан сэргийлэх олон нийтийн оролцоонд тулгуурласан ийм хяналт үнэлгээ мэдээллийн ийм системийг дэмжих ийм программ хангамж ер нь хийгдсэн үү? Тэгээд энэ үүргийн санд яагаад ингээд мөнгө төвлөрүүлдэггүй юм бэ? Нийгмийн даатгал дээр бас нөхөн төлбөр олгоно гэж байгаа. Яах вэ зүгээр мэдээлэл технологийг дэмжих үүднээс нийгмийн даатгалынх нь нөхөн олговрыг нөхөөд олгочих уул нь болгох бололцоотой. Нийгмийн даатгалаар хуулиар хориглочихсон зүйл байхгүй шүү дээ.

Тэгэхээр иймэрхүү зүйлийг би тодруулж асууя.

Б.Заяабал: Ажлын хэсэг. 5 номерын микрофон нээе.

Б.Мягмарнаран: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя.

Цахим хөгжлийн нөөц Харилцаа холбооны яам Мягмарнаран.

Тэгэхээр яг түрүүний таны ярьдаг эрсдэлтэй гэнэтийн янз бүрийн эрсдэл дээр бид бүхэн саяын жишээн дээр ярихад бол И Монгол платформ дээр 2 хоногийн дотор хөгжүүлэлтийг хийж эрсдэл мэдэгдэх системийг оруулсан байгаа. Тэгээд Засгийн газраас барьж байгаа Монгол Улсын Ерөнхий сайдын чөлөөлөх бодлогын хүрээнд бид бүхэн open.eri буюу тэр хүсэлт илэрхийлэх боломжийг бүх төрлийн платформ системүүдтэй холбох боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байгаа.

Тэгэхээр одоо хүсэлтийг хүлээж авсны хүрээнд бид бүхэн Засгийн газрын 11 11-ийн нэгдсэн өргөдөл гомдлын санд бүртгээд холбогдох байгууллага дээр уламжлалаараа ажиллаж байгаа. Бас бид нарын хувьд бол яг таны ярьж байгаа нөгөө төрөөс үзүүлэх дэмжлэгийн төрөл дотор уул нь бол нөгөө 9 төрлийн татварын бус дэмжлэг дотор дэвшилтэт технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгосон патент эзэмшигчид шагнал урамшуулал олгох гээд уул нь суучихсан. Тэгтэл бид нар нөгөө энэ сангийнхаа бүрдэл хэсгийг бүрдүүлж чадахгүй байгаа. Гишүүний ярьж байгаа нөгөө бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан гэж байдаг. Тэр нь болохоор арай өөр чиглэлийн нөгөө алслагдсан иргэдэд харилцаа холбооны үйлчилгээг хүргэх чиглэлээр ийм өөр сан байгаад байгаа. Энэ нь болохоор мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих сангийн хувьд бол уул нь ийм бүрдэл, төсвийн бүрдлийг бүрдүүлчих юм бол хэрэгжүүлэх боломж уул нь байгаа.

Б.Заяабал: Эрдэнэбат гишүүнд нэмэлт тодруулга байна. Микрофон нээе.

С.Эрдэнэбат: Сая яах вэ тэгээд Ерөнхий сайд чиглэл өгөөгүй бол гэдэг юм уу энэ хүүхэд эндээгүй байсан бол саяын энэ И Монголиа платформ дотор хүүхдийн аюулгүй байдалтай холбоотой, орчны аюулгүй байдалтай мэдээлэх ийм функц орохгүй л байх нь л дээ. Яг ний нуугүй хэлэхэд. Тэгэхээр яг энэнтэй ижилхэн зөвхөн хүүхэд гэлтгүй орчны аюулгүй байдал барилга байшин аюултай энэ хэрвээ хүчтэй салхи гарлаа гэж бодоход Улаанбаатар хотод хэдэн самбар нь унаж ирж хүний толгой дээр унах юм. Барилга барьж байгаа компаниудынх нь хамгаалалтынх нь

систем нь хэр найдвартай юм. Дээрээс хэдэн тонны шивлээр төмөр уналаа гэж бодоход тэрийг нь даах хэмжээний хамгаалалтаа хийсэн юм уу үгүй юм уу гэдэг юм уу иймэрхүү аюулгүй, эс үгүй бол аюултай тэр зон бүсээр явахгүй байх гэдэг юм уу иймэрхүү мэдээлэх системийг л цаашдаа И Монголиагаар дамжуулаад хийх юмыг ийм үүргийн сангаар дамжуулаад оруулж өгөх бодлогыг хийгээч л гэж би хэлээд байгаа юм.

Б.Заяабал: Гишүүд санал хэлчих шиг боллоо.

Ингээд асуулгын хариутай холбогдуулан үг хэлэх Улсын Их Хурлын гишүүдийн нэрсийг авъя. Байхгүй байна. Ингээд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113.3.4-д заасны дагуу асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн Золжаргал гишүүн асуулгын хариутай холбогдуулан үг хэлэхийг урьж байна аа. Гишүүний микрофоныг нээе.

Ж.Золжаргал: Энэ хэлэлцэж байгаа асуудал маань Ерөнхий сайдад хандсан асуулгын хариу байгаа. Тэгэхээр яагаад энэ асуулгыг тавьсан бэ гэхээр Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль гэдэг их сонирхолтой хууль байдаг. Аягүй ийм их хүлээлт үүсгэчихсэн энэ салбар дээр ажиллаж байгаа залуучууд дэмжлэг авна гээд тэгээд 2 жил ерөөсөө хэрэгждэггүй. Тэгээд хэрэгжүүлэх гэхээр үндсэн шалтгаан нь болохоор нөгөө Засгийн газрын кабинетын бүрдүүлэгч яамдууд төсвийн ерөнхий захиран зарцуулагч нар нь хоорондоо ойлголцдоггүй тал тал тийшээ хараад суучихдаг учраас Ерөнхий сайдын анхаарлыг хандуулъя. Тэгээд тэр тусмаа энэ салбартаа анхаарч ажиллаж байсан хүн нь солигдсоны дараа бүүр чиг анхаарах хэрэгтэй байна гэж. Тэгээд кабиныхаа зарчим дээр хоорондоо ярьж сууж байгаад шийдлээ гаргаад шийдчихээч гэсэн агуулгатай ийм асуулт байсан юм аа.

Сая тэгээд ер нь юу болж байгааг нь бол танилцуулахыг сонслоо. Тэгээд энэ одоо 3 дахь сайд энэ Цахим инновац, харилцаа холбооны сайд хийж байна. Энэ хууль нь хэрэгжихгүй 3 сайдын нүүр үзэж байгаа юм. Тэгэхээр бид нар нэг дүгнэлт хийх хэрэгтэй байгаа юм. Энэ ер нь хийж чадах юм уу үгүй юу гээд. Хэдэн төгрөг энэ салбарт эргэлдэж байгаагаа, хэдэн төгрөгөөр цахим систем авсныгаа Монгол Улс мэддэггүй. Энийг мэдэхийн тулд 3 удаа 3 сайдын үед 3 удаа мэдээлэл авч байгаа. өчигдөр нэг мэдээлэл сонссон. Бас арай нэг цэгцтэй болж байгаа. Гэхдээ л тэр 1 их наяд, 2 их наяд төгрөг дотор чинь барилга байшин энэ тэр холилдоод л явж байгаа юм.

Тэгэхээр хэдэн төгрөг байгаагаа мэдэхгүй байгаа учраас хэдэн төгрөгөөр дэмжлэг болгохоо мэдэхгүй.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэл явуулж байгаа татвар төвлөрүүлсэн орлогынх нь 40 хувиар буцаад салбарыг нь дэмжинэ ээ. Манай энэ IT-чид шинийг бүтээж байгаа дэвшилтэт технологи хийж байгаа залуучууд байж бай битгий бүгдээрээ баруун руу явчих, битгий бүгдээрээ Ази руу явчих ядаж битгий бүгдээрээ Станы орнууд руу явчих гээд хүлээлгээд байдаг. Тэгээд хэдэн төгрөгөөр дэмжих гэхээр тоо нь байхгүй. Хэдэн төгрөгийн татвар төлснийг мэдэхгүй. Тэгээд энийг асуусан байхгүй юу? 40 хувь гэдэг чинь хэдэн төгрөг юм. Хариу байхгүй, одоо ч байхгүй байгаа.

Дараагийнх нь болохоор энэ нөгөө тусгай сангуудаас 5 хувийг нь бөөгнүүлээд тэндээсээ грант болгож дэмжинэ гэсэн. Тэгэхээр тэр нь нөгөө хуулийн зохицуулалт

байхгүй учраас болдоггүй гээд байгаа. Тэгэхээр энэ үндсэндээ Баатархүү сайдыг байхад, Батшугар сайдыг байхад, одоо Номин сайдыг байхад яригдаж байгаа асуудал. Тэгээд Засгийн газар байгаа. Тусгай сангийнх нь удирдлагууд нь байгаа. Одоо тэгээд нөгөө хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гээд санал оруулсан гэж байна. Тэгээд заримыг нь аваагүй байгаа гэсэн тийм зүйл ярьж байгаа. Энэ асуултуудын бас нэг зүйл нь болохоор нөгөө хэдэн төгрөгийг юунд зарж байгаагаа мэдэхийн тулд мэдээллийн технологи гэдэг ангилал хэрэгтэй байна аа. Бүртгэл тэгээд кибер аюулгүй байдал онцгой чухал болж байгаа учраас кибер аюулгүй байдлыг хангах эдийн засгийн ангилал хэрэгтэй байна аа.

Энэ 2 зүйлийг Инновац, цахим бодлогын байнгын хорооноос 2025 оны нэг 1 сарын 4-ний тогтоолоор оруулаач гэдэг ийм шийдвэрийг Засгийн газарт чиглэл өгсөн байдаг. Тэгээд энэ ангилал орсон байна гэдэг хариу гарч байгаа юм.

Тэгэхээр өөрөөр хэлбэл үүнээс цааш Монгол Улс хэдэн төгрөгөөр цахим систем аваад байгаагаа тусад нь бүртгэнэ. Кибер аюулгүй байдалд зарцуулж байгаа мөнгөө тусад нь бүртгэнэ. Тэр нь энэ шинэ аюулгүй байдлын зах зээлдээ нэмэр болох нэг ийм арай тодорхой хариулт бол нэг байна. бас нэг асуулт нь нөгөө төрийн хуулийнхаа дагуу бол төр мэдээллийн технологи үйлдвэрлэхээс аль болохоор зайлсхийнэ. Аль болохоор ч юу байх вэ дээ төр ер нь үйлдвэрлэхгүй гэсэн тийм зарчим байдаг тэгээд тэр нь хэрэгждэггүй. Төсвийн хөрөнгөөр маш их ийм программ хангамж системүүд хийгддэг. Энэ яагаад хэрэгжихгүй байна вэ гэдэг асуулт тавьсан. Энэ дээр бол цахим дэлгүүр ажиллуулж байгаа, ингээд тогтоол шийдвэрүүд гарч байгаа гэсэн нэг тиймэрхүү ерөнхий 1 тийм юм байна.

Сүүлийнх нь болохоор дэвшилтэт технологиудын жагсаалт нөгөө дэмжлэг авах жагсаалтыг энэ оны 3 дугаар улиралд гаргана гэсэн тийм тайлбар байна лээ. Тэгэхээр энэ ингээд гарах байлгүй дээ тэгээд ерөнхийдөө бол шууд хэлэхэд энэ салбар нь өөрөө Монголд чухал нөгөө одоо далайд гарцгүй тэгээд IT болон хил хязгаар хамаагүй гээд ингээд зөндөө гоё юм ярьдаг. Тэгээд Монголчуудын залуу үеийнхэнд маш их хэрэгтэй байна гээд ярьдаг. Тэгээд энэ хууль нь хэрэгжихгүй. Ингээд 2 жил болоод 3 сайдын нүүр үзлээ. Тэгэхээр одоо нэг хийх дүгнэлт юу вэ гэхээр одоо энэ удаад ингээд Засгийн газар кабинет анхаараад, тогтоол гаргаад хийж байгаа бол маш сайн байхсан.

Намрын чуулган хүртэл энэ ажлууд нь хийгдэх байх. Хэрвээ энэ ажил урагшаагаа явахгүй бол ер нь энэ яам байх хэрэгтэй юу үгүй юу гэдэг асуудлыг намрын чуулган эхлэхээр тавья гэж бодож байгаа.

Б.Заяабал: Улсын Их Хурлын гишүүд үг хэлж асуулт асууж дууслаа.

Манай Улсын Их Хурлын гишүүдээс энэ цахим мэдээллийн технологи дээр нэлээдгүй анхаарал хандуулдаг манай Улсын Их Хурлын гишүүн Золжаргал, Анар, Мөнхбат, Соронзонболд, Галбадрах нарын 5 гишүүнээс Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэж дууслаа.

16.14 цаг

Дараагийн асуудалдаа оръёо.

Дөрөв.Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн хүрээнд Монгол Улсад үр өгөөжтэй, ашиглах боломжтой, олон талт хэрэгцээ шаардлагад нийцсэн хиймэл дагуулын талаар судлан санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт

Дараагийн асуудалдаа оръёо. Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэж эхэлье.

Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны дарга Улсын Их Хурлын гишүүн Чинбаатарын Анарыг дэд хорооны санал, дүгнэлтийг танилцуулахыг урьж байна. Ингээд микрофоныг нээж өгье өө. Ажлын хэсгийг байвал оруулаарай.

Ч.Анар: Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хороо Үндэсний хиймэл дагуулах өргөх төслийн хүрээнд Монгол Улсад үр өгөөжтэй ашиглах боломжтой олон талт хэрэг хэрэгцээ шаардлагад нийцсэн хиймэл дагуулын талаар судлан санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Анар, Баярмаа, Золжаргал, Пүрэвдаваа, Соронзонболд нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бөгөөд тус ажлын хэсгийн бэлтгэсэн санал, дүгнэлтийг 2026 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд ажлын хэсэгт танилцуулагдсан зарим мэдээлэл нууцын журмаар ирсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-д заасныг үндэслэн тус ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хаалттай хэлэлцэх горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Ажлын хэсгийн зүгээс компани нь түүний толгой компани болох Талс групп болон олон улсын хиймэл дагуулын шийдэл нийлүүлэгч 5 байгууллагатай биечлэн уулзалт хэлэлцүүлэг хийж хиймэл дагуулын хүчин чадал, давтамжийн боломж, хөөргөх хугацаа, хөөргөлт, түүний үнэ, даатгал, газрын станц, модуляц, санхүүжилтийн нөхцөл зэргийн үзүүлэлтүүдийг харьцуулан авч үзээд дараах дүгнэлт санал, дүгнэлтийг гаргасан байна.

Нэгдүгээрт ТЭЗҮ хуучирсан, өртөг өндөр, хүчин чадал хязгаарлагдмал, бүрэн эзлэгдээгүй санхүүжилтийн нөхцөл, нэмэлт зардлын эрсдэл зэргээс шалтгаалан үндэсний хиймэл дагуулын төслийн одоогийн хувилбарыг дахин нягтлах, ТЭЗҮ-ийг шинэчлэх, шинэчилсэн ТЭЗҮ нь Хилийн бүсийн холбоо, гамшгийн үеийн нөөц, холболт, төрийн болон хувийн хэвшлийн хэрэглээ, газрын станц олон улсын гарцын нөөц холболт ирээдүйн хүчин чадлын өсөлт Санхүүжилтийн олон хувилбарыг хамарсан байх.

Хоёрдугаарт, төслийн нийт өртгийг зөвхөн хиймэл дагуулын үндсэн үнээр бус хөөргөлт, даатгал, газрын станц, гэтвэй, хэрэглэгчийн терминал, сургалт үйл ажиллагаа, засвар үйлчилгээ, санхүүжилтийн хүүгийн зардал, сансрын ашигтай байршлыг сонгох зэргээр нийт эзэмшлийн өртгөөр тооцож олон улсын боломжит хувилбаруудтай нэг ижил шалгуураар харьцуулах.

Гуравдугаарт, Монгол Улсад хамгийн үр ашигтай хувилбарыг тодорхойлохын тулд олон улсын зах зээлд ирэх боломжит хувилбаруудыг ТЭЗҮ санхүүжилт хэрэгжүүлэх хугацаа, нийт өртөг, хүчин чадал гэсэн нэгдсэн шалгуураар дахин харьцуулж үнэлэх нь зүйтэй гэж үзжээ.

Дэд хорооны хуралдаанаар ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэх үед ажлын хэсгийн зүгээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасныг үндэслэн үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулж, санал, дүгнэлтийн хамт Эдийн засгийн байнгын хороонд танилцуулж нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн хүрээнд Монгол Улсад үр өгөөжтэй, ашиглах боломжтой, олон талт хэрэгцээ шаардлагад нийцсэн хиймэл дагуулын талаар судлан санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны, Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны санал, дүгнэлт, тогтоолын төслийг хэлэлцэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Заяабал: Анар гишүүнд баярлалаа.

Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны санал, дүгнэлт болон дэд хорооноос боловсруулсан тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү.

Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя.

Асуулт асуух гишүүд Уянгаа гишүүнээр тасалъя. Уянгаа гишүүний микрофоныг өгье.

Б.Уянга: Өдрийн мэнд хүргэе. Тогтоолын төслийн 1.1 дээр байгаа энэ шинээр ТЭЗҮ-ийг боловсруулах дээр тогтоод асууя. Ер нь ТЭЗҮ-ийг боловсруулах үндсэн шаардлага нь юу байгаа билээ? Хэчнээн төгрөг шаардагдах бол? Төсөв мэдээж улсын төсөв дээр суух байх, хугацаа маань яах бол? Заавал ингэх хэрэгтэй юу, эсвэл одоо байгаа техник эдийн засгийн төслийнхөө зардлын хэсэг дээр нь санхүүжилтийн хэсэг дээр нь тооцооллыг нь ахиж боловсруулах нэг аль болох л тийм төсөв ихээр шаардахгүй байдлаар тэгэхдээ өнөөгийнхөө эдийн засгийн нөхцөл байдалд нь апдэйтлэх хүрээнд найруулах нь зөв байсан юм биш үү? Тэгэхээр 1.1 дээр хариулт авъя.

Б.Заяабал: Анар дарга. Инновац цахим бодлогын дэд хорооны дарга Анар гишүүн хариулна.

Ч.Анар: Уянга гишүүний асуултад хариулъя аа. Энэ тогтоолын ТЭЗҮ нь энэ боловсрогдсон юм байна л даа. Энэ бол Япон улсын падокогоор 2011-2013 онд боловсрогдсон байгаа юм. Тухайн үедээ бол маш сайн хийж боловсруулсан ТЭЗҮ.

Гэхдээ 2011 оноос чинь хойш үндсэндээ 15 жил өнгөрчихсөн. Сансрын технологи гэдэг өөрөө 1, 2 жилээр хөгжиж байдаг. Тэгэхээр эдийн засгийн үнэ өртөг бол энэ хугацаанд бодит байдлаараа 5 дахин буусан байгаа.

Тэгэхээр 2024 онд энэ ТЭЗҮ-ээ оруулж ирэхдээ сонирхолтой нь энэ 3 хиймэл дагуулын төслийг судалгаа хийсэн байгаа юм. Энэ маш сайн хийсэн судалгаа. Тандан судалгаа, өргөн нэвтрүүлгийн, улс даяарх, өргөн нэвтрүүлгийн хиймэл дагуул, харилцаа холбооны хиймэл дагуул гээд үндсэн 3 хиймэл дагуулын хүрэн дээр ТЭЗҮ хийгдсэн. Гэхдээ Их Хурал руу үндсэндээ 1.2 их наяд төгрөгийн төсөвтэй хиймэл дагуулын төсөл нь орж ирэхдээ зөвхөн харилцаа холбооны хиймэл дагуулын төсөл орж ирсэн. Тэгэхээр өнөөдрийн 2025, 2026 оны байдлаар бид нарт техникийн нөхцөл нь маш их өөрчлөгдсөн. Эдийн засгийн хувьд үнэ өртөг дэлхийн зах зээл дээр дор хаяж 3-аас 5 дахин өртөг буусан тул заавал ч үгүй техник эдийн засгийн ТЭЗҮ-ийг дахин шинэчилж хийх ёстой буюу бид нар 10 жилийн өмнөх ТЭЗҮ-ээр хийх нь бол үндэслэлгүй гэж ажлын хэсэг дүгнэсэн болно оо.

Б.Заяабал: Баярлалаа гишүүд асуулт асууж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасныг үндэслэн Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны боловсруулсан тогтоолын төслийг уншиж танилцуулъя аа.

Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын ч чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн энэ талаар дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

1.Монгол Улсын өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээ, аюулгүй байдлын шаардлагад нийцсэн орчин үеийн техникийн шийдлийг нэвтрүүлсэн дамжуулах хүчин чадал, нийт өртөг, санхүүжилтийн нөхцөл, хэрэгжих хугацаа, ашиглалтын үр өгөөжийг зах зээлийн боломж чадавхад нийцүүлж тооцсон байдлаар төслийн ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулах.

2.Төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулахдаа дамжуулах хүчин чадал, санхүүжилтийн нөхцөл, хэрэгжих хугацаа, хөөргөлт, даатгал, газрын станц, сургалт, зөвлөх үйлчилгээ, ашиглалт, засвар үйлчилгээ, санхүүжилтийн зардал, сансрын ашигтай байрлал болон ашиглалтын үр өгөөж зэрэг нийт эзэмшлийн өртгөөр үнийн шалгуурыг гаргаж олон улсын зах зээл дээр санал болгож байгаа боломжит хувилбаруудыг харьцуулан судалж сонгон шалгаруулалтыг ил тод явуулах.

3.Төслийн санхүүжилтийг Монгол Улсын төсөв, гадаад өрийн хэмжээнд дарамт учруулахгүй байх чиглэлээр урт хугацаатай, нэн хөнгөлөлттэй зээл, экспортын санхүүжилт, лизинг, хамтарсан компани байгуулах, ашиглалтын орлогоор эргэн төлөх зэрэг санхүүжилтийн уян хатан хувилбаруудыг судалж хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд даалгасугай гэсэн ийм Улсын Их Хурлын тогтоолын төсөл байна аа.

Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулан санал гаргах Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү.

Санал гаргах Улсын Их Хурлын гишүүд байхгүй байна.

Улсын Их Хурлын хуралдааны чуулганы дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т заасныг үндэслэн Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны боловсруулсан тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулъя аа.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэнэ үү.

Батчимэг гишүүн ороогүй байна.

Саналын томъёоллыг уншъя аа.

“Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

75 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Инновац цахим, бодлогын хөгжлийн дэд хорооны санал, дүгнэлт болон дэд хорооноос боловсруулсан “Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар авах Зариг арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны дарга Улсын Их Хурлын гишүүн Чинбаатарын Анар танилцуулна аа.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж хуралдаан дуусаж байна.

Хуралдаан үүгээр өндөрлөснийг мэдэгдье.

Хуралдаанд оролцсон гишүүддээ баярлалаа.

16.27 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМ

